



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-43

1.Хаврын тариалалтын урьдчилсан дүн мэдээний талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох	6-20
2.Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийх, Монгол үүлдэр, омгийн адууны удмын санг хамгаалах асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт	20-35
3.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	35-36
4.Улсын Их Хурлын даргын 2024 оны 79 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт	36-43

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
06 дугаар сарын 24-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 30 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: П.Батчимэг, Г.Ганбаатар;
Чөлөөтэй: Т.Аубакир, Ж.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Л.Мөнхбаясгалан;
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Наранбаатар.

Нэг.Хаврын тариалалтын урьдчилсан дүн мэдээний талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Хяналт шалгалтын газрын референт К.Пүрэвсүрэн нар байлцав.

Хаврын тариалалтын урьдчилсан дүн мэдээний талаарх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа, Ц.Идэрбат, Б.Бат-Эрдэнэ, Б.Бейсен нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, М.Бадамсүрэн, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг 17 цаг 09 минутаас 17 цаг 35 минутад хуралдааныг даргалав.

Байнгын хорооны гишүүд Хаврын тариалалтын урьдчилсан дүн мэдээний талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийх, Монгол үүлдэр, омгийн адууны удмын санг хамгаалах асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Мөнхнасан, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал эмнэлгийн хяналт, баталгаажуулалтын газрын дарга Б.Батсүх, Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй, биотехнологийн сургуулийн захирал Д.Гүрбазар, Татварын ерөнхий газрын Бүртгэлийн хэлтсийн дарга Т.Баярмаа, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн Мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч Д.Анхтуяа, судлаач, доктор Г.Сувдаа, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Д.Гантулга, Б.Батбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Хяналт шалгалтын газрын референт К.Пүрэвсүрэн нар байлцав.

Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийх, Монгол үүлдэр, омгийн адууны удмын санг хамгаалах асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, У.Отгонбаяр, Ж.Батжаргал, М.Мандхай, З.Мэндсайхан, Б.Бейсен нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Мөнхнасан, судлаач, доктор Г.Сувдаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийх, Монгол үүлдэр, омгийн адууны удмын санг хамгаалах асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэв.

Уг асуудлыг 18 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Мөнхнасан, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал эмнэлгийн хяналт, баталгаажуулалтын газрын дарга Б.Батсүх, Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй, биотехнологийн сургуулийн захирал Д.Гүрбазар, Татварын ерөнхий газрын Бүртгэлийн хэлтсийн дарга Т.Баярмаа, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн Мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч Д.Анхтуяа, судлаач, доктор Г.Сувдаа, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Д.Гантулга, Б.Батбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Хуралдаан даргалагч М.Ганхүлэг тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

М.Ганхүлэг: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	13
Татгалзсан	3
Бүгд	16

81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. Улсын Их Хурлын даргын 2024 оны 79 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Хяналт шалгалтын газрын референт К.Пүрэвсүрэн нар байлцав.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 79 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат, Ж.Батжаргал, У.Отгонбаяр, Б.Бейсен нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр, Б.Бейсен нар үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Улсын Их Хурлын даргын 2024 оны 79 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэв.

Уг асуудлыг 18 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 22 минут үргэлжилж, 24 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 70.8 хувийн ирцтэйгээр 18 цаг 52 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхим 16 цаг 30 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 54.2 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааныг үргэлжилж байгааг мэдэгдье.

Хэлэлцэх асуудал. Гишүүдийн ирц танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар гишүүн ирсэн байна, Сонгобайн Замира гишүүн ирсэн байна, Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна, Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн байна, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн ирсэн байна, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн ирсэн байна, Агваанлуvsангийн Ундраа гишүүн ирсэн байна, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна, Сүрэнжавын Лүндэг гишүүн ирсэн байна, Бадрахын Найдалаа гишүүн ирсэн байна, Болдын Уянгаа гишүүн ирсэн байна аа.

Хэлэлцэх асуудал. 4 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, хаврын тариалалтын урьдчилсан дүн мэдээний талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох.

Хоёрт, Малын генетикийн нөөцийн тухай хуулийн биелэлтийг хяналт шалгалт хийх. Монгол үүлдэр омгийн адууны удмын санг хамгаалах асуудлыг судалж, санал дүгнэлт гаргах шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал дүгнэлтийг сонсох.

Гуравт, Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Дөрөвт, Улсын Их Хурлын даргын 2024 оны 79 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал дүгнэлтийг сонсох.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалд оръё.

Хаврын тариалалтын урьдчилсан дүн мэдээллийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсьё.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Д.Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлого хэрэгжилт зохицуулалтын газрын дарга.

Энхбаяр сайд мэдээллээ танилцуулъя.

Ж.Энхбаяр: Эрхэм гишүүдийнхээ амрыг эрье. Хаврын тариалалтын ажлыг технологийн хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр холбогдох албан даалгавар гарч зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлээд явж байна. Улсын хэмжээнд 2025 оны хаврын тариалалтад цаг агаарын төлөв байдалтай уялдуулан 5 сарын 7-ны өдрөөс эхлүүлж урьдчилсан байдлаар 310.1 мянган га-д үр тариа, үүнээс 264.8 мянган га-д улаан буудай, 12.1 мянган га-д төмс, 9.2 мянган га-д хүнсний ногоо, 32.2 мянган га-д малын тэжээл, 126.3 мянган га-д тосны ургамал нийтдээ 479.5 мянган га-д тариалалт хийгдэж, 74 хувийн гүйцэтгэлтэй байна аа. Үр тариа, төмсний тариалалт дууссан. Малын тэжээл, хүнсний ногооны тариалалт хийгдэж байна.

Тариалалтын дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улаан буудай 38.2 мянган га-гаар, төмс 4.7 мянган га-гаар, хүнсний ногоо 2.6 мянган га-гаар, малын тэжээлийн таримал 16.2 мянган га-гаар тус тус буурсан байна. Бусад таримал болох арвай, вандуй, эрдэнэ шиш, гурвалжин буудай, овъёос, эмийн ургамал 2.5 мянган га-гаар, тосны ургамал 15.3 мянган га-гаар тус тус ахиу тариалагдсан байна аа. Энэ жил 245.8 мянган га-д чанар сайтай уринш боловсруулж бэлтгэхээр төлөвлөсөн. Аж ахуйн нэгж, иргэд 95.2 мянган га-д уриншийн 1 дүгээр боловсруулалтыг хийсэн ийм мэдээтэй байна. Тариалангийн гол бүс нутгууд болох Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал, Орхон, Сайхан, Төв аймгийн Аргалант, Батсүмбэр, Баянхангай, Баянцогт, Жаргалант, Сүмбэр, Угтаалцайдам, Дархан-Уул аймгийн Хонгор, Дорнод аймгийн Халх гол, Чойбалсан, Чулуунхороот сумдаар 30 градусаас дээш халж, хөрсөнд 50 градусаас дээш халалт өгч аагим халуун өдрүүд олон хоног үргэлжилсэн. Хур тунадас багатай, хөрсний нөөц чийгийн хангамж муутай байгаагаас таримлын соёололт харилцан адилгүй байна.

Цаг уур, орчны шинжилгээний газраас ургамлын ургалтын хугацаанд тариалангийн бүс нутгуудад 6, 7 саруудад хур тунадас багатай, хэт халалт үргэлжлэх хоногийн тоо их байх урьдчилсан төлөв гарсан бөгөөд цаашид таримал ургамлын хөнөөлт организм, хөнөөлт организмын тархалт нэмэгдэж, ургацын чанарт сөргөөр нөлөөлөх нөхцөл үүсэж байна гэж үзэж байна.

Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян өрнүүлэх тухай Монгол Улсын Засгийн газрын 47 дугаар тогтоолоор батлуулж, тэргүүлэх чиглэл бүхий 5 зорилт, 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Атар-4 аяны хүрээнд хүнс, хөдөө аж ахуй үйлдвэрлэл эрхлэгчдийн эргэлтийн болон хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлд хамруулахаар арилжааны 10 банкт хамтран ажиллах гэрээг байгуулж хөнгөлөлттэй зээл олгох ажлыг зохион байгуулж байна.

2025 оны 6 дугаар сарын 20-ны байдлаар газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд арилжааны 10 банкаар дамжуулан 128.3 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл, 50.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийг нийт 599 иргэн, аж ахуйн нэгжид олгосон байна. Малын тэжээлийн тогтвортой хангамжийг бүрдүүлэх, сэлгээний таримлын нэр төрөл экспортод чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 166 дугаар тогтоолоор атар газрыг тариалангийн газар шилжүүлэх шийдвэр гарч нийт тариалангийн эргэлтийн талбайг 71.2 мянган га-гаар нэмэгдүүлээд байна аа.

Цаашид анхаарч хэрэгжүүлэх ажлын талаар.

Хөрсний элэгдэл эвдрэлээс хамгаалах, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэн доройтлыг бууруулах зорилгоор олон наст тэжээлийн ургамал тариалах, хашаажуулах ойн зурвас байгуулах ажлыг үргэлжлүүлж энэ чиглэлд төр хувийн хэвшлийн оролцоог улам бүүр нэмэгдүүлэх шаардлагатай байна аа. Таримал ургамлын шинэ сорт бүтээх үйл ажиллагааг дэмжих, нутагшсан болон ирээдүйтэй сортын үр үйлдвэрлэх, тариалангийн бүс нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон нутагшсан сортын торгон болон баталгаажсан үрээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна. Тариалангийн бүс нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирох ургах чадвар өндөр таримлыг нутагшуулж, сэлгээнд оруулах, тэжээлийн таримлын дотоодын борлуулалтыг дэмжих замаар газар тариалан, мал аж ахуйн хослуулан хөгжүүлэх чиглэлээр шат дараатай арга хэмжээг авах шаардлагатай байна.

Тариалангийн техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үргэлжлүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэн газар тариалангийн салбарт гарах сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцох боломжийг бүрдүүлж, ухаалаг газар тариаланг хөгжүүлэх, усалгааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх замаар тариалангийн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилт тавиад байна. Газар тариалангийн үйлдвэрлэлд ашигт таримлын тариалалтыг нэмэгдүүлэх, газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хадгалалт, нийлүүлэлт, борлуулалт, ложистикийн сүлжээг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байна

Хөдөө аж ахуйн салбар ажиллах хүчний хомсдолд гүнзгий ороод байна. Үүнийг нөхөх боломжит гарц нь механикжуулалтыг нэмэгдүүлэх гэж үзэж байна. Дотооддоо үйлдвэрлэж чаддаггүй хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисын, гааль НӨАТ-аас чөлөөлөх нь малчид, тариаланчид учирч болох санхүүгийн дарамтыг бууруулах оновчтой шийдэл болно оо гэж үзэж байгаа болно.

Дээрх нөхцөл байдалтай холбогдуулан Улсын Их Хурлаар дараах асуудлуудыг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна аа.

Импортлох мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаан буудайн гурилын гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг шуурхай горимоор батлуулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах, эрсдэлээс хамгаалах зорилгоор Хөдөө аж ахуйн даатгалын тухай хуулийн төслийг боловсруулан батлуулах зэрэг ажлыг төлөвлөж байна аа. За илтгэж дууслаа.

Б.Бейсен: Энхбаяр сайдад баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? нэрсээ өгнө үү. Идэрбат гишүүнээр тасаллаа. Найдалаа гишүүн асуулт асууя.

Б.Найдалаа: Товчхон ганц хоёрхон асуулт асууя. Тариалалт, үр тариа, улаан буудай, хүнсний ногоо, төмс, малын тэжээл бүгд буурсан байна л даа төлөвлөснөөсөө. Ганцхан нөгөө тосны ургамлын тариалалт нэмэгдсэн юм байна. Тэгэхээр яг энэний учир шалтгаан юу юм бол оо. Хэрвээ ингээд тариалалт төлөвлөснөөсөө юм уу эсвэл өнгөрсөн жилээс буураад байх юм бол бид нарын нөгөө хүнсний хувьсгал, хүнс, хүнсний аюулгүй байдал юу болох вэ. Энэ дээр шалтгаан нь нь яг юу юу байсан юм бол оо та энэ дээр дурдаач.

Хоёрт нь, гурилын импортын гаалийн татварыг тавихтай холбоотой. Энэ ямар нэг холбоотой юу, холбоогүй юу? Тэгээд цаашдаа яг хүнсний хувьсгалыг үр дүнд хүргэхийн тулд тариалалтыг тогтмол нэмэгдүүлэх, таны ярьж байсан атар газрыг нэмж ашиглах ч гэдэг юм уу ингээд энэ тогтвортой өсөлтийг хангахгүй л бол жилээс жилд ингээд өсөж, буураад байх юм бол тогтвортой бодлого үр дүн гарахгүй болов уу гэж санаа зовж байна л даа. Та энэ дээр нэг тайлбар өгөөч ээ.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя. 4 номер.

Ж.Энхбаяр. Ингээд голлох улаан буудайн тариалалт унасан учир шалтгаан бол Улсын Их Хурлаар баталсан Гаалийн албан татвартай холбоотой. Үндсэндээ улаан буудайн тарих нь эдийн засгийн хувьд үр өгөөжгүй болж хувирсан. Бид 2020, 2021, 2022, 2023 онд дотооддоо 100 хувь улаан буудайгаа тариад, үндэсний үйлдвэрүүдээ 100 хувь дотоодын бүтээлээр хангаж, эх орны гурил хэрэглэж байсан. Хууль гарсантай холбогдуулан импорт эрс нэмэгдсэн. Энийгээ дагаад тариалалт огцом унасан. Өнгөрсөн жил 200 мянгаас 148 мянга болтлоо 50 гаруй мянган га-гаар унасан бол энэ жил ноднин үеэс ахин 30 гаруй мянган га-гаар уначхаад үндсэндээ нийт нэг 88 орчим мянган га талбай улаан буудайн тариалалт уначхаад байна. Энэний шууд үр дагавар буюу бид нар 150-иад мянган тонн улаан буудай энэ жил хүнсний хангамжид дутагдана гэсэн үг. Импортоос авахаас аргагүй байдал үүслээ.

Улаан буудай дутаад эхэлнэ гэдэг маань өөрөө малын тэжээл үйлдвэрлэлийг шууд унагааж байгаа юм. Улаан буудайн 70 хувь нь гурил болж, 30 хувь нь малын тэжээл болж, гахай, тахиа, сүү, өндөгний аж ахуйнуудад нийт малчдад малын тэжээл болж очдог. Энэ үйлдвэрлэл давхар унаж байгаа. Гурил үйлдвэрлэгчид үндсэндээ сул зогсож байгаа. Үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт 40 хувь руу орсон 100 хувиас 40 хувь руу орж байна гэсэн үг. Тэгээд энэ шийдвэртэй холбоотойгоор улаан буудай өөрөө газар тариалангийн үйлдвэрлэлийн гол таримал байдаг. Улаан буудай тарьж байж бусад ургамал нь дагаж сэлгээний таримал болж дагалдаж хөгждөг. Сэлгээ ээлжлэн таригддаг гэсэн үг. Улаан буудайн таримал тариалалт унахаар дагасан сэлгээний бодлого унаж байна. Ингээд тосны ургамал руу буюу энэ хятадын зах зээлд зориулсан захиалгат таримал руу тариаланчид шилжиж байна гэсэн үг. Үндсэндээ бид эх орны хөрсөнд ургасан бүтээгдэхүүнээ Хятадын зах зээлд өгөөд өөрсдөө ОХУ-аас ОХУ-ын тариаланчдын тарьсан гурил улаан буудайг авч хэрэглэдэг боллоо л гэсэн үг буюу Монгол Улсын газар тариалан үр ашигт байдлаа алдаж байна.

Нөгөө дотоодоосоо хангах Үндэсний аюулгүй байдлаа хангах, хүнсний аюулгүй байдлаа хангах гол нөгөө зорилтот бодлогууд маань ингэж гол амжилтууд маань үндсэндээ ингээд 50 хувь алдагдаад байна. Иймд энэ гурилын тэжээлийн татвартай холбоотой асуудлыг дахин хэлэлцэхийг Их Хуралд өргөн барьдаг учир нь тэр. Үндсэндээ арван тавхан хувийн тэр татварын нөлөөлөл гэж ямар хүчтэй зохиж байгааг л бид их сайн ойлгох хэрэгтэй. Гишүүд маань энэ олон дахин нугалж зардаг, асар их ашиг олдог, үгсэн хуйвалддаг, монопол, Монголын монголд ургасан улаан буудай чанаргүй, Оросынх сайн. Монголын гурилын үйлдвэрлэлүүд чанаргүй, оросынх сайн гэх мэтийн ийм суртал ухуулга өмнөх хууль батлахад их нөлөөлж ийм үгнүүд их ярьж байсан. Гэтэл тэр жоохон юм нь үгүй гэдэг нь одоо энэ нэг жил хүрэхгүй хугацаанд энэ үйлдвэрлэл энийгээ дагаад олон мянган ажлын байр, энд олгогдсон олон тэрбумын зээл, хөрөнгө оруулалт эрсдэлд орж байна.

Хамгийн гол мессеж бол газар тариалангийн салбарт хөрөнгө оруулаад ажиллаж байсан Үндэсний дотоодын компаниудын урам зориг энэ салбарт хөрөнгө оруулах идэвхийг үндсэнд нь ингээд энэ зогсоосон гэсэн үг. Ингээд тогтвортой байсан төрийн бодлогыг Ерөнхийлөгч нь санаачлаад эх орон бодлого болгоод явж байхад ингээд өөрчилдөг юм бол өөр тогтвортой бизнес орчин байхгүй гэж үзэж маш олон бизнес энэ салбараас хөрөнгө оруулалтаа татаж, тариалалтаа багасгаж, өнжиж байгаа байдал анзаарч байна.

Б.Бейсен: Найдалаа гишүүн тодруулъя.

Б.Найдалаа: Гурилын хувьд үр тариа буудайны хамт ойлголоо. Зүгээр бусад хүнсний ногоо бас буурсан байна. Төмс ч юм уу буурсан байна. Тосноос бусад нь буурчихсан байгаад байна л даа. Энэ дээр тогтвортой цаашид өсгөх талаар тэр гурилын татвартай холбоогүйгээр өөр ямар бодлогын авч хэрэгжүүлэх вэ, ямар дэмжлэг хэрэгтэй байгаа юм бол оо. Нэг л нэг тогтвортой нэг өсөлт нь хангагдахгүй л байгаа харагдаад байна.

Б.Бейсен: Энхбаяр сайд, 4 номер хариулъя.

Ж.Энхбаяр: Нэгдүгээрт энэ бусад ер нь таримлын бас тоо хэмжээ багасаж байгаатай энэ цаг уурын байдалтай холбоотой. Үндсэндээ ид яг төмсний энэ төмс хүнсний ногоо ид тариалах үед энэ хэт халалт 30-аас дээш градус, хөрсөн дээрээ 50 градус хүрч халсан халалт одоо болтол үргэлжилж байна. Ахиад нэг 10 хоног үргэлжлэхээр байна. Энэ халалт яг тариалалтын үеийг үндсэндээ үр ашигтай бус болгож байгаа тул улсууд тарилтыг эрс багасгаж байна гэсэн үг. Энэ бас нэг нөлөөлж байгаа.

Хоёрдугаарт төсвийн тодотголуудаар салбарт байсан хөрөнгө оруулалтууд буюу энэ салбарын дэмжлэгүүдийг маш хүчтэй танаж байгаа. Ноднин намар 130 тэрбумаар танасан, одоо бараг 90 гаруй тэрбумаар ахиад танаж байна. Ийм мессежүүд өөрөө тэр үйлдвэрлэлийг тогтвортой явуулах, хөрөнгө оруулалт хийх тэр бизнесийнх нь урам зориг гэнэ үү...

Б.Бейсен: Идэрбат гишүүн асуулт асууя. .

Ц.Идэрбат: Өдрийн мэнд хүргэе. Тэр гурилын татвартай холбоотой асуудал дээр бол та зөвхөн нэг өнцгийг нь ярьж байна л даа. Миний хувьд дэмжихгүй байсан шалтгаан бол наад гурил үйлдвэрлэгчдийг чинь бас хамгаалмаар байгаа байхгүй юу. Нийгмээрээ ингээд л хэт үнэ нэмдэг луйварчид эд нар гээд ингээд л яриад байдаг. Энийгээ л ялгаж салгачих нэг жилийн хугацаа байна. Энийгээ ялгаж салгаад оруулаад ирээч ээ. Тэрнээс Монголын гурилын үйлдвэр хөгжөөсэй, Оросын гурилыг шүтээд байгаа юм ердөө байхгүй. Өнөөдөр тэгээд харин Байнгын хороон дээр энэ нэг тогтоол гараад тэр шударга өрсөлдөөнийхөө юмыг хяная гэж байгаа юм байна лээ. Тэгээд би тэр утгаар нь дэмжиж байгаа гэж ингэж хэлэх гэж байгаа юм нэгд.

Хоёрт, энэ хэлэлцэгдэж байгаа асуудалтай холбогдуулаад 3 юм байна. Зуншлага сайнгүй байна. Хөрсөн дээрээ 50 хүртэл халж байна. Энэ бол яг нөгөө улаан буудайн тариалалтад яг өнөөдрийн хувьд маш их сөргөөр нөлөө үзүүлж эхэлнэ. Тэгээд энэний хариу арга хэмжээ байгалийн эсрэг яалтай билээ. Гэхдээ

одоо нөгөө үүлэнд нөлөөлөх буудах ийм хариу арга хэмжээнүүд ер нь авч байгаа юу гэдгийг нэгдүгээрт.

Сая зүүн талаараа ингээд явлаа. Бас тийм одоохондоо аятайхан л байна. Гэхдээ ер нь цаашдаа хэцүүдчихэж магадгүй байдалтай байна нэгд. Хоёрт, сая зүүн бүсээр явахад нэг асуудал гарч ирж байгаа нь энэ өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах нь ялангуяа мал аж ахуй, малчид малаа эртхэн борлуулж, мөнгө болгож цааш нь хийх асуудал байгаа. Гэтэл яг зөрөөд энэ мах экспортолдог компаниуд энэ мах бэлтгэгч нарын хооронд нэг үл ойлголцол ер нь олон жил болж байгаа юм билээ дээ. Цүнхний буюу зөвшөөрөлтэй компаниуд килограмм тутмаас нь мөнгө авдаг. Одоо адууны мах зүүн бүсэд 8500 байсан бол сая бид нарыг очиход 6500 болчихсон. Нэг адуунаас 120, 130-ийн дундаж килтэй адуу гэж бодоход 300-гаад мянган төгрөг нь зүгээр л зөвшөөрөлтэй компанийн нөхрийн карманд ордог, малчинд ямар ч өгөөж байхгүй нэг ийм юм. Тэгэхээр энийг ер нь Хөдөө аж ахуйн яам та маш сайн анхаарч нэг талд нь гаргахгүй бол ер нь ингээд нэг ужгирчихсан нэг ийм хөгийн юм малчдыг шулдаг нэг ийм юм бүр явчихсан юм байна лээ шүү гэж. Энэ дээр ер нь та ямар мэдээлэлтэй байгаа вэ гэж асуух гэж байгаа юм.

Гуравдугаарт одоо үе үеийн сайд нарт л ярьж байна даа. Энэ отрын бүс нутгийн асуудал. Мэдээж улс орныг хэцүү үед энэ отрын бүс нутгийг ашиглах нь зүйтэй. Гэтэл яг отрын бүс нутгаар ажлын хэсэг гаргаад Байнгын хорооны ажлын хэсэг гаргаад ахлаад ингээд явсан. 10 хэдэн отрын бүс нутгийн зарим нь нэлээдгүй дийлэнх нь баймаар байна гэдэг ийм зүйл, зарим нь отрын бүс нутгаас гармаар байна. Гармаар байгаад нь энэ Булганых, энэ Говьсүмбэрийнх, манай Хэнтий аймгийн Хэрлэнбаян-улааных. Хэрлэнбаян-Улаан бол улсын хэмжээнд бүүр 200 мянган га маш том нутагтай. Тэгээд тэнд яг өнтэй байсан ч л хүн шавж байдаг, цаг хүндэрсэн ч хүн шавж байдаг. Тэгээд энэ бол ингээд нэг 20 жил явчихсан. Маш их малын халдварт өвчний голомт болгоод хаячихсан. Тэгээд энийг нэг жоохон багасгаач ээ гэдэг юм ярьсан...

Б.Бейсен: 4 номер Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ жилийн цаг уурын байдалтай холбоотойгоор өвөлжилтөд тодорхой хэмжээнд хүндрэл учирна. Улаан буудай 150 мянган га-гаас наашгүй дутна. Төмс хүнсний ногоо дутна. Тэгэхээр 2026 оны төсөв дээр тодорхой хэмжээний эх үүсвэрүүдийг тавьж байна. Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр Байнгын хороо арга хэмжээ, санал санаачилга гаргаж, дэмжиж өгвөл их баяртай байна. Махны зөвшөөрөлтэй холбоотойгоор махны мах зөвхөн экспорт хийх эрх бүхий үйлдвэрүүд экспортод гаргаж байгаа юм. Тэгэхээр тухайн аль оронд экспортолж байгаатай холбоотой тухайн орны мал эмнэлэг, хорио цээрийн байгууллага ирээд магадлан итгэмжлэл хийдэг. Жишээлбэл Ойрх Дорнодын орнууд гарахад бол тэр стандарт нь тэдний шашны тэр халаалт стандартын дагуу бэлтгэн нийлүүлэгдэх техник технологи тэр дүрэм журмыг биелүүлсэн байх ёстой гэх мэтчилэн.

Мөн БНХАУ махны нэлээн томоохон худалдан авагч. Мөн Хятадын хорио цээрийн байгууллагууд өөрсдийн магадлан итгэмжлэлийн дагуу авдаг. Тэрнээс мах гаргая гэсэн болгон гаргах бололцоо байхгүй. Дандаа үйлдвэрийн аргаар бэлтгэгдэж итгэмжлэл авсан аж ахуйн нэгжүүд. Отрын бүс нутгийн асуудал. Отор гэдэг маань өнөөдөр нийт бэлчээрийн 70 гаруй хувь үндсэндээ бэлчээрийн гүнзгий доройтолд орсон, ургамлын ургац, гарц, идмэг сайтай ургамлын нэр төрөл цөөрсөн.

Отрын бүс нутаг нэг талдаа нүүдлийн мал аж ахуйд эрсдэл учирсан нөхцөлд мал аж ахуйг авч гарах, нөгөө талдаа бэлчээрийн ургамлыг хамгаалах ийм бодлогыг давхар хэрэгжүүлж байгаа.

Тэгэхээр бид энэ отрын бүс нутгийг хашаа саравч, худаг ус, тэнд байгаа дэд бүтцийг сайжруулж, чанаржуулах энэ арга хэмжээг, тооцоо судалгааг хийгээд хэрэгжүүлээд явж байна. Нөгөө талаар отрын бүс нутгаас одоо яг гаргая гэж хэлэхэд эрт байна. Ахиад нарийвчилсан тооцоо судалгаагаа хийе. Мэдээж байгаа тодорхой эх үүсвэрийн хүрээнд бид ажил албаа зохион байгуулж байгаа. Улсын хэмжээнд 20 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг энэ отрын бүс нутгийн менежмент зохион байгуулалт тэр бэлчээр ашиглалт, хамгаалалтын ажлыг л хариуцаад явж байгаа. Хүн хүч, техник санхүү хаанаа ч хүрэхгүй ийм байдалтай л байгаа. Хариу арга хэмжээ буюу энэ халалттай яаж тэмцэх үү гэхэд Байгаль орчны яамандаа бид нар хүсэлт тавьсан. Байгаль орчны яам шаардлагатай хэмжээний нөгөө үүлэнд нөлөөлөх сум пуужингийн нөөцийг хангалттай бүрдүүлсэн. Одоо яг таатай нөхцөлийг л хүлээгээд экспедицүүд үүргээ авчихсан ингээд ажиллахад бэлэн байдалтай байгаа. Харамсалтай нь олигтой хурын үүл орж, үүлийн фронт орж ирэхгүй үүсэж өгөхгүй байгаа. Энэ бол бэлтгэл ажлууд нь хангагдаад хүлээж байгаа гэдгийг хэлье.

Энд би ахиад л нэг зүйл хэлмээр байна. Энэ хариу арга хэмжээн дээр энэ ургамал хамгааллын түмэн арга хэмжээ байдаг. Харамсалтай нь тэр манайх энэ яамандаа тусалж дэмжих ёстой энэ мэргэжлийн шинжлэх ухааны байгууллагууд чинь бүгд өөр байгаа харьяанд. Хөдөө аж ахуйн салбарын нэгдмэл энэ бодлогыг, цогц байдлыг л бүрдүүлж өгөхийг би дахин дахин л Байнгын хороондоо санал тавиад байгаа юм. Энэ чинь халалтын эсрэг арга хэмжээнүүд байна. Ургамал хамгааллын ургамлын бордоонууд шингэн бордоонууд цацах ёстой болж байна. Агро технологийн шинэ арга ухаан байх ёстой болж байна, бүтэн жил боллоо. Нэг өгүүлбэр ч би сонсоогүй энэ хүрээлэнгүүдээс. Хөдөө аж ахуйн салбарт та ийм юм анхаарах ёстой, ингэж ажиллах ёстой, ийм малын үржил селекц, ийм ургамал хамгаалал, ийм шинэ үр сорт, ийм шинжлэх ухааны юм байхгүй. Тэгэхээр энэ нэгдмэл...

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Тийм, таны яг энэ ярьж байгаа шинжлэх ухааны байгууллагуудыг нэгтгээд энийг авахыг би бол ёстой 100 хувь дэмжинэ ээ. Одоо яамны зүгээс энэ асуудлаа Байнгын хороонд оруулаад, Байнгын хороо эндээс шийдвэр гардаг тэр процесс нь яаж явах юм байгаа юм. Энэ одоо нэг хөдөө аж ахуйн байнгын шинжлэх ухааны байгууллагыг тэнд тэс өөр юм нэгтгэж ер нь яг яах гээд байдаг юм. Энэ шинжлэх ухааны байгууллагуудыг ингээд нэг нэгтгээд нэг энэ Боловсролын яам, аль яам нь ч билээ ингээд хамж аваад байдгийг би эсэргүүцдэг хүмүүсийн нэг байгаа. Одоо буруу зөв буруу гэж боддог хүний бол нэг ээ. Тэгэхээр яамны зүгээс энэ Байнгын хороо руугаа ийм асуудлуудаа оруулбал Байнгын хороо яаж дэмжих ёстой юм. Тэр хүрээнд нь одоо дэмжихэд бэлэн байгаа.

Наад мал махны асуудал чинь та их л хөндий хариулж байна даа. Яг газар дээрээ наадах чинь нэг хэдхэн компанийн монополийн асуудал, цаана нь асар их мөнгө явдаг, дунд нь малчид хохирдог урьд нь явж байсан юмыг нэг хэдэн монополууд л яах гээд байгаа юм билээ дээ. Яг асуудлыг нь гүн ухвал би таныг ухаж үзээсэй гэж...

Б.Бейсен: Тэгэхээр үг хэлж байгаа юм уу тиймээ. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа үүлэнд зориудаар нөлөөлөх наад Байгаль орчны яам чинь ажлаа хийгээгүй шүү дээ өнгөрчихсөн. 4 сарын сүүл, 5 сард аль хэзээний ажил явах ёстой байсан яваагүй байхгүй юу. Одоо та нар үүл хайгаад ч олдохгүй. Наадах чинь нэгэнт хуурайшилт үүсчихсэн учраас бүх үүл чинь үүсэх боломжгүй болчихож байгаа. Энэ удаа бол Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам хариуцлага алдсан учраас хөрсөнд нөлөөлж байгаа юмаа гэдгийг би албан ёсоор хэлье.

Хоёрдугаарт, ирэх жил Цөлжилтийн конвенцын хурал болно.17 дугаар бага хурал Монгол Улсад нэг дэлхийн 193 орон ирж байгаа. Энэ цөлжилтийн конвенцын хурал дээр энэ хөрстэй холбоотой асуудал хүссэн хүсээгүй хамгийн гол асуудал байгаа цөлжилт учраас. Тэгээд энэ дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам жоохон бодлого гаргаад, төсөл бичээд олон улсаас энэ том конвенцын Монгол Улсын Ерөнхийлөгчийн бас нэлээн томоохон дэмжлэгтэйгээр явж байгаа энэ том ажил дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам маань бас энэ тодорхой хэмжээний хөрсжүүлэх, шимжүүлэх, цөлжилтийн эсрэг энэ ажлыг нэг төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгээд тодорхой хэмжээний аж ахуйн нэгжүүддээ байдаг юм уу, хувийн хэвшлээ уриалаад тэгээд тэндээсээ тодорхой гаднаас мөнгө босгох ажлуудаа хийчихмээр л байгаа юм даа. Тэгээд та хэд маань яаж ажиллаж байгааг би яг сайн мэдэхгүй байна.

Төсвийн тодотголтой холбоотой асуудлууд яригдаж байгаа. Хэмнэлтийн тодотгол гэж би ойлгож байгаа Засгийн газрын явуулж байгааг. Тэгээд энэ дээр нөгөө нэг та хэдийн маань арайхийж олгоод явж байгаа зээлд нөлөөлчих вий дээ. Одоо миний сонссоноор аялал жуулчлалын хөнгөлөлттэй хүүгийн татаастай олгогдох зээлд нөлөөлж байгаа сурагтай байна лээ. Тэгэхээр энэ хэмнэлтийн тодотгол гэж байгаа учраас энэ дээрээ та хэд маань нэг бодлого явуулах гээд, хүнсээр хангачих гээд яваад байдаг. Гэтэл нөгөө талдаа яалт ч байхгүй төсөв мөнгө хүрээтэй холбоотой асуудал яригдаад ингээд зээл нь татагдчих вий дээ гэдэг дээр бол яг нэг санаа зовж байна. Тэгээд энэ зээл олгогддоогоороо олгогдоод цаашдаа явах ёстой. Олон аж ахуйн нэгжүүд энэ дээр бол нэгэнт төрийн бодлого гаргаад өөрсдөө зээлээ аваад тодорхой хэмжээнд би зарим нь бизнесээ солиод, энэ бизнес рүү ороод ингээд явж байгаа цаг хугацаанд бол аж ахуйн нэгж, иргэдэд хүндрэл битгий учруулаасай гэж хүсэж байгаа.

Тэгээд энэ зээл татагдахгүй биз дээ. Энэ дээр та бүхэн маань яг бодитоор ажиллаж байгаа биз дээ. Энэ газар олголттой асуудлууд яалт ч байхгүй Газрын хуультай холбоотой асуудлууд хөндөгдөнө. Олон удаа л хөндөж байгаа энэ. Газар олголт зогссоноос улбаатайгаар дараа дараагийн үр дагаврууд энд гараад байгаа. Тэгээд энэ дээр та хэд маань яг энэ хүнс, хөдөө аж ахуй талаасаа ямар бодолтой байгаа вэ? Нөлөөлж байгаа юу, нөлөөлөхгүй байгаа юу? Гаалийн импортын татварыг тэглэхтэй холбоотой хуулийн төсөл нь яаралтай горимоор өргөн баригдаад ингээд явж байгаа. Энэ дээр тэр баруун аймгуудаас саналууд ирээд байгаа. Ядаж ингээд Монгол Улс даяар нийтлэг мөрдөгдөх биш хэсэгчилж болохгүй юу? Нэгэнт Монгол Улс Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гээд шилжээд явчхаж байгаа учраас тэглэсэн хэлбэр нь жишээлбэл баруун аймаг дээрээ байж болдоггүй юм уу гэдэг ийм асуултыг асуугаад өгөөч ээ...

Б.Бейсен: Энхбаяр сайд 4 номер хариулъя.

Ж.Энхбаяр: Гурил тэжээлийн гаалийн татварыг тэлэхтэй холбоотой зохицуулалт хэрхэн хийгдэх вэ гэж. Баруун бүс нутгийг үнэ нөлөөллөөс ангид байлгахын тулд энэ хууль хэрвээ Их Хурлаар дэмжигдэж батлагдсан тохиолдолд дагаж гарах Их Хурлын тогтоолын төсөл Батжаргал гишүүн ахлаад энэ тогтоолын төсөл Их Хурлаар давхар орно. Тэрэн дээр баруун бүсийг үнийн өсөлтөөс хэрхэн хангах вэ, баруун бүсийн гурил тэжээлийн тогтвортой байдлыг хэрхэн зохицуулах вэ гэсэн ийм бодлогын асуудлууд бүгд туссан байгаа. Мөн баруун бүсийн газар тариаланг хэрхэн хөгжүүлэх энэ бодлогын асуудлыг оруулах асуудал байгаа юм. Баруун бүсэд гол 2 тулгуур Увсын Баруунтурууны сангийн аж ахуй наана нь Завханы Тэс. Энэ 2 дээр нэлээн бодлого гаргаж тэжээлийн таримал, тэжээлийн бааз нэлээн өргөтгөх, шаардлагатай бол гурилын үйлдвэр усалгааны систем гээд юмнуудыг бид нар манай ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа.

Мэргэжлийн хөрс судлаач, агрономичид, техникийн улсууд ингээд тухайн нутаг орны гаралтай төрийн өндөр гавьяа шагналтай салбарын тэргүүний гавьяатууд орсон ийм агрономичдын хөдөө аж ахуйн мэргэжилтний баг үнэлгээ хийж байгаа юм. Ингээд бид нар оруулна. Их Хурал дээр. Баруун бүс нутгийн тэр газар тариалан тэжээлийн аж ахуйг дэмжихийн тулд бодлогын хөнгөлөлттэй зээлийг оруулж ирнэ. Тэгээд Их Хурал дээр л хэрхэн шийдэхээс шалтгаална тийм. Үнэхээр тэр төсөл хөтөлбөр хасагдаж байгаа. Очих зээлийн хэмжээ багасаад л, хасагдаад л байна. Гол нь манай энэ салбар хамгийн их сайн өсөлт үзүүлж байгаа салбар. Бүтээмж. Энэ жил 20 гаруй сая толгой мал авчихлаа, төл авчихлаа.

Хөнгөн арьс шир, ноосны үйлдвэрлэлийн боловсруулалтын түвшин, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтууд нэлээн боломжийн хийчихлээ. Ноолуураа Монгол Улс анх удаа сүүлийн 30 жилд үндэсний үйлдвэрүүд нь аваад бид нар 100 хувь самнадаг болчихлоо шүү дээ. Зөвхөн энүүгээр гэхэд л олон 100 тэрбумын нэмүү өртөг Монголд үлдэх болж байна. Хүнсний үйлдвэрүүдийн өргөтгөлүүд өмнөх хүнсний хувьсгалын үр дүнгүүд аягүй сайнаар гарч ирж байна. 50 гаруй үйлдвэр ашиглалтад орчихлоо. 400 гаруй нэр төрлийн бараа шинэ сав баглаа боодолтой болоод, шинэ нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглээнд нэвтрээд эхэллээ. Ингээд нэг тогтвортой нэг 28 үйлдвэрийн салбарын энэ хүнсний хувьсгал атрын 4, цагаан алт гэсэн энэ хөдөлгөөнүүдийг ингээд дэмжээд тогтвортой явуулчихвал ер нь бодитой үр дүн. Энэ чинь хөдөө аж ахуйн салбар чинь 600 мянган хүний ажлын байрыг хангаж байгаа, нийгмийн тогтвортой байдлаа хангаж байгаа салбар шүү дээ. Тэгэхээр энд л жоохон бодлогын л юм жоохон дутаад бид нар дэмжлэг үнэхээр эх үүсвэр их бага байна. Байгаа юмаа л чадан ядан хүргээд л заримыг нь орхиод л заримыг нь хойшлуулаад л ингээд л байж байгаа.

Тэр копын арга хэмжээнд Байгаль орчны яам үүрэг аваад ажиллаж байгаа. Тэр хүрээнд бид нар цөлжилт ялангуяа нүүдлийн МАА-гаа хамгаалж гарахын тулд бэлчээрийн хамгаалалт, бэлчээрийн доройтолтой тэмцэх нь манай энэ хөдөө аж ахуйн суурь болоод байгаа юм. Энэний холбогдох бид нар тооцоо судалгаа, олон улсын байгууллага санал юмаа бэлдээд ажиллаж байгаа. Энийг бас бид нар их боломж гэж үзэж энэ дээр холбогдох төсөл хөтөлбөрөө танилцуулахаар бэлдэж байгаа. Баярлалаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Импортын татвар тэглэх баруун бүс гэж яах вэ зохицуулалт явж байгаа гэж ойлголоо. Зээлээр шийдэгдэж байгаа юм байна гэж ойлголоо. Тэглэгдсэн хэлбэр хэвээрээ үлдэхгүй юм байна гэж ойлголоо. Тэр Цөлжилтийн конвенцын талуудын бага хурал дээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам юу ч хийгээгүй юм байна лээ. Та хэд маань Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам зөвхөн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд найдаад ээлгүйгээр энэ дээрээ уул нь олон улсаас мөнгө босгох маш өндөр боломж байгаа учраас аж ахуйн нэгжүүддээ, төсөл бичдэг, тэндээс мөнгө олж амьдардаг энэ тэрээс нь авхуулаад бүгдэд нь зарлаад л, хэлээд л боломжоороо л тэр төсөл хөтөлбөрүүдийг олон улсад гаргаж мөнгө босгох дээр л ажилламаар юм байна лээ. Наад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам чинь бол Баянгол дүүргийн АН-ын хороо болчихсон байна лээ шүү ний нуугүй хэлэхэд. Тэнд бол төсөл бичдэг байтугай төсөл удирддаг ч нэг ч хүн байхгүй. Тэгээд энэ бол маш харамсалтай байгаа. Тэгээд дараа дараагийн арга хэмжээг та хэд маань санаачилгаа аваач ээ л гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Б.Бейсен: Би нэг асуулт асууя. Есөн-Эрдэнээс. Энэ улаан буудайн тариалалтын хэмжээг сая хэллээ. Рапс хэчнээн талбайд тариалсан га-д. Нөгөө талаар Ерөнхийлөгчийн хүнсний хувьсгалын хүрээнд 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн дотооддоо хангая гээд ярьж байгаа. Яагаад гэвэл хүнсний аюулгүй байдал бас алдагдсан байгаа. Та бүхэн мэдэж байгаа. Хавдрын ихсэлтийн 80 хувь нь цэвэр хүнсний аюулгүй байдал алдагдсантай холбоотой залуужиж байна. Тийм учраас энэ төмс хэчнээн га-д тариалсан юм, байцай хэчнээн га-д тариалсан урьдчилсан мэдээгээр, лууван хэчнээн га-д, огурцы, помидор нь хэчнээн га-д тариалсан байна. Хүлэмжийн аж ахуй дээр чинь одоо гол нь зонхилон юу тариалсан байна. Энэ талыг асууя.

Манай Монголын төмс маань хаваржин энэ ОХУ Киргиз рүү гарлаа. Тэгэхээр Энхбаяр сайд энэ боловсролын байгууллагуудын дотуур байр ясли, цэцэрлэгийн хоолны төсөв гээд тавигдаж байгаа. Энийг эд нартай ярьж байгаад дотоодын энэ тариаланчдаа хүнсний үйлдвэрлэгчдээ дэмжээд бас тийшээ хамтын гэрээ хийгээд борлуулалт дээр нь анхаарахгүй бол бас болохгүй юм шиг байгаа юм. Саяын мэдээллийг сонсьё. 5 номерт хандаж байна. 4 номер, 5 номер юм байна.

Сайд хариулах гэж байгаа юм уу Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Тосны ургамал 118.8 мянган га болж нэмэгдэж байгаа. Нийт бид нар 103 мянган га гэж тооцсон бол 118 хүрч таригдсан. Хүнсний ногоо ер нь дунджаас 16-гаар 17 мянга тарьдаг байсан бол 9 мянга болж огцом унаж байгаа. Төмс 17 мянга хүрч таригддаг байсан бол 11 болж бас мөн унаж байгаа. Малын тэжээл нэг 140, 50 мянган га хүрч тарьж байсан бол энэ жил 31 мянгатай байна. Одоо малын тэжээлийн тарилтын хугацаа ахиад нэг 14 хоног гэнэ. Хоёр 7 хоногийн хугацаа байна. Энийг жоохон идэвхжүүлээд зохион байгуулбал энэ 31 мянга нэг 50, 60 мянга руу нэлээн дөхөх болов уу гэсэн ийм бодолтой байна. Тэгээд ер нь ингээд тодорхой болчхож байгаа л даа. Ингээд тарилт яг ид ургалт бутлалтын үеийн цаг агаарын төлөв байдал. Ингээд бид энэ жил бол үр тариан дээр ч тэр, төмс хүнсний ногоон дээр ч тэр, малын тэжээл дээр ч тэр дутагдал үүснэ ээ. Зайлшгүй одоо импортоор авна. Энэ дээр бол үнийн өсөлт явагдана. Инфляцын нөлөөнд орохоос орох нь тодорхой болчхоод байгаа юм.

Тэгэхээр энийг одоо шийдэхийн тулд тодорхой хэмжээний төсөв арга хэмжээг л төсөв дээр тавиад оруулж ирнэ дээ. Тэгээд тэрүүгээр л дамжуулаад ийм зүйл яаралтай л арга хэмжээ авах хэрэгтэй. Энэ жилийн онцлог бол бид урьдчилан тооцоонуудаа эрт хийж чадаж байгаа буюу талбай дээр маш хатуу одоо анхны тарилтаас авхуулаад таримлын ургамлын үе шат болгон дээр хяналтууд хийгдээд яваад байгаа буюу тоо үнэн байгаа, багцаа ба тоо биш үнэн тоонууд гараад байгаа. Өмнө нь улаан буудай их тарьсан гэххээд цаанаа өөр төрөл тарьчихдаг ч юм уу тийм биш. Яг бодит байдлаа гаргаж чадаад байгаа юм. Тэр экспорт дээр бид нар ноднин 240 гаран мянган тонн төмс аваад, ОХУ, Киргиз, Узбек гээд орнуудад экспорт маш сайн боломжийн хэмжээнд экспорт гарчихсан. Монголын төмс их сайн үнэлэгдэж байгаа. Одоо сая Узбекийн хөдөө аж ахуйн салбарынхан ирчихсэн Монголын төмсийг үргэлжлүүлэн авах хүсэл сонирхлоо илэрхийлж байгаа.

Тэгэхээр энэ хөдөө аж ахуй гэдэг үнэхээр их эмзэг гэдгийг л бид нар хаа хаанаа ойлгож байна. Тогтвортой, улс төрийн хувьд ч тэр, хууль эрх зүйн хувьд ч тэр, бодлогын хувьд ч ингээд тогтвортой л явж байхгүй бол болохгүй юмаа гэдгийг л саяын энэ хууль эрх зүйн энэ нэг жилийн хугацааны энэ савлагаа, энэ хэрүүл, энэ улс төржилт бол үнэхээр маш хүчтэй сөрөг нөлөөлж байна. Маш олон улсууд энд бизнест хийсэн хөрөнгө оруулалтаа татсан, оруулахаа зогсоосон, тариаланчид тарилтаа багасгасан. Ийм л одоо муу үр дүнд хүрчхээд байна даа тариалангийн салбар дээр.

Б.Бейсен: Энхбаяр сайд аа, би одоо энэ баруун аймгаас сонгогдсон гишүүний хувьд бас дотоодын тариаланчдаа дэмжээд Баянхонгорын даргын хувьд санал өгсөн. Гэтэл одоо би баруун аймгийн гурилын юуг импортын татварыг тэглэсэн энэ тэр гээд муу нэр авч байгаа. Тийм учраас баруун аймагт нэг анхаарахгүй бол одоо баруун аймгуудад ган болж байна ерөөсөө. Одоо бүр пресс өвс, хивэг, тэжээл өгч байна гэж байна шүү дээ. Зуслан гарч чадахгүй. Ноднин чинь нэг шуудай хорголжин хивэг нь 85 мянга хүрсэн. Пресс өвс 45 мянга хүрсэн. Тийм учраас энэ татварын асуудал дээр баруун аймгууд, зүүн аймгууд дээр ер нь анхаарч үзэхгүй бол бас онцлог харагдаад энэ үнэхээр хүнд байдалд байгаа энэ дээр бас анхаараарай гэж хэлье.

Гишүүд асуулт асууж дууслаа. Мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Ирсэн юугаар. За Батжаргал гишүүнээр тасалъя. Идэрбат гишүүн асуулт асууя. Үг хэлье.

Ц.Идэрбат: За нэг хоёр, гурван асуудал байгаа юм. Хөдөө аж ахуйн салбар хамгийн сайн дэмжлэгтэй явж байгаа салбар шүү. Энэ бол одоо Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэр Цагаан алт хөтөлбөр сая ноолуурын юман дээр хэчнээн төгрөг гаргав. Сүүлд нь 500 тэрбумын пиксел хүртэл гаргаад ингээд л явж байгаа шүү дээ. Үүний үр дүнд энэ ноолуурууд бол сайн авсан байна лээ. Анх би Их Хурлын чуулган дээр ярьж байхад ноолуурын худалдан авалт ер нь хэн авах нь мэдэгдэхгүй байсан. Энэ харин сайн зүйл болсон. Энэ хүнсний хувьсгалын асуудал байна. Үнэхээр дотооддоо үйлдвэрлэдэг болъё гээд ингээд явсан. Үүний үр дүн ч бас тодорхой хэмжээнд гарч байгаа шүү дээ.

Би бол одоо хөдөө аж ахуйн салбар тийм айхтар нэг их нүд үзүүрлэгдчихсэн юм байхгүй гэж ингэж хэлэх гэж байгаа юм. Та болохоор дандаа л хөдөө аж ахуйн салбар ямар ч дэмжлэггүй гэж яриад байдаг. Энэ бол одоо бас Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан энэ ажил үр дүнгээ өгч байгаа шүү. Та бол ганц гурил

дээр ингэлээ гэж яриад байгаа. Хөдөө аж ахуйн яам уул нь жилийн хугацаанд гурилын үнээ зохиомлоор нэмсэн юм уу, үнэхээр зах зээл нь ийм юм уу гэдгийг л хагалаад өгчихсөн л болоо байсан шүү дээ. Үнэхээр зах зээл нь ийм байх юм бол энийг чинь дэмжих ёстой шүү дээ. Тэгэхгүй одоо бол энэ чинь би энэ Нарантуул захаар ч явлаа, Бөмбөгөрөөр ч явлаа иргэд бол яг л нөгөө монгол гурилаа идээд л, нэг килийн тийм орос гурил зарагдаж байгаа юм байхгүй юм байна лээ шүү дээ. Нарантуул дээр очоод асуухад. Тэр хаашаа яваад байна вэ гэхээр тэр боов боорцог руу л яваад байгаа тийм л юм байгаа юм байна лээ шүү. Яг амьдрал дээрээ тийм. Тэрийг би бас нэг хэлье гэж ингэж бодож байгаа юм.

Одоо энэ хаврын тариалалтын энэ ургацын асуудал байна. Одоо ийм ган гачиг болж байгаа үед бараг тариагүй нь ч оносон юм биш үү. Тэгээд одоо энэ чинь үүл буудаад яах юм одоо, буудах гэсээр байтал наадам болно, бороо залгана болц нь хойшилно зөндөө л юм болно. Махны асуудал дээр би таныг онцгой анхаараасай гэж байгаа юм. Таны үг тийм нэг албаны бараг энэ сүүлийн 10 хэдэн жил явж ирсэн тийм л үг байна. Манай зүүн бүсийн гишүүдтэй зүүн бүсийн энэ үйлдвэр эрхэлдэг хүмүүс ирж уулзсан. Явж байсан юмыг нь явуулахаа болиод нэг хэдхэн компани Махны холбоо гэдэг нэрийн доор одоо тэнд нь тэгээд хэн хохирч байна гэхээр зүүн бүсэд зуд болоод хонь үхэр байхгүй, одоо байгаа нь хэдэн адуу байгаа. Тэгээд хэдэн адууг нь заавал Улаанбаатарт авчирч нядлуулдаг ийм үйлдвэрийн лоббинууд маш ихээр явж байгаа юм. Үүнээс болоод нэг кило адууны мах нь 2 мянган төгрөгөөр уначхаад байгаа. Одоо бүр авахаа болих юм билээ ашиггүй учраас.

Тийм учраас нэг ийм зүйлүүд рүүгээ бас нэг жоохон тийм нэг өнгийж хараасай гэж ингэж бодож байгаа юм. Энэ чинь мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэлийн бараг гол ажил шүү махны экспортын асуудал. Одоо энэ геополитикийн нөхцөл байдал энэ булангийн орнууд манайхаас авах уу, үгүй юу. Зөндөө л юм гарах гээд байна. Өгсөн ч, авсан ч, мөнгөө олж авч чадах уу, үгүй юу гэдэг асуудал наад мах бэлтгэгч нарт чинь үүсэх юм байна лээ шүү дээ. Тэгэхээр бид хаашаагаа яаж борлуулах юм. Төр гэж байгаа бол, яам гэж байгаа бол энэ нэг хэдэн болсон болоогүй зөвшөөрөлтэй компаниудын үгэнд ормооргүй байна гэдгийг би бас хэлмээр байгаа юм аа. Явж байсан юмыг явснаар нь тэгээд явуулаад, энэ экспортынхоо махныхаа юм руу анхаараач ээ гэж би бас танд хэлье гэж ингэж бодож байгаа юм.

Отрын бүс нутаг дээр мэдээж төрийн бодлого юмаа ойлголгүй яах вэ, дэмжилгүй яах вэ. Гэхдээ үнэхээр нэг төр тэнд байлгах гээд байгаа бол байлгахын дайтай байлгаж, дүрэм журам хамаг юмыг нь бас нэг мөрдүүлж ингэхгүй бол манай Хэрлэнбаян-Улаан хавартаа хэдэн үхсэн малын сэг үлддэг. Тэнд байгаа хүмүүс нь тэрийг нь зайлуулдаг, баахан малын халдварт өвчний голомтууд үүсдэг ийм л юм байгаа шүү. Би энийг одоо гурав дахь Хөдөө аж ахуйн сайддаа хэлж ярьж байна аа гэдгийг бас би хэлье ээ.

Б.Бейсен: Гишүүд асуудалтай холбогдолтой үг хэлж байгаа. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн үг хэлнэ ээ.

М.Бадамсүрэн: Хөдөө аж ахуйн салбар байгаль цаг уурын хараат байдалд байдаг эрсдэлтэй салбар аа. Тийм учраас бүх л улс орон хөдөө аж ахуйн салбарт зориулсан тодорхой бодлого хэрэгжүүлдэг. Тэгээд үүнтэй санал нэг байгаа төдийгүй энэ хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааг дэмжих нь зүйтэй. Дэмжих ёстой гэдэгтэй санал нэг байна. Яагаад гэвэл хөдөө аж ахуй хөдөөгийн иргэдийн хамгийн

чухал амьдран сууж байгаа ийм газар. Тэгээд энэ байгаль цаг уурын өөрчлөлт, энэ олон улсын геополитикийн нөхцөл байдал гээд олон зүйлээс болоод хүндрэлтэй зүйл гарч байгаа. Гэхдээ Монголын төр юм чинь энэ дээр зохицуулалт хийх хэрэгтэй гэдгийг санал нэг байгаа.

Тэгэхээр нэгдүгээрт бол энэ зүүн бүсийн иргэд, аж ахуйн нэгжүүдээс бидэнд хүсэлт ирүүлсэн. Тийм учраас өнөөдрийн Байнгын хорооны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралд зүүн бүсээс сонгогдсон гишүүд бүгдээрээ ер нь сууж оролцож байгаа гэсэн үг. Яагаад гэхээр ард иргэд бид нарыг сонгохдоо төр төлөөлж энэ ард иргэдийн төлөө ажиллаа аа, дуу хоолойгоо илэрхийл ээ гээд сонгосон. Тийм учраас бид бол үг хэл, үзэл бодлоо илэрхийлнэ. Энэ бол бидэнд ард түмнээс өгсөн мандат. Тийм учраас үгүй ээ, та одоо хаан юм уу, заан юм уу. Та Идэрбат гишүүнийг үг хэлэхээр дундуур байна лээ. Таныг үг, асуулт хариулж байхад бид нар дундуур нь нэг ч удаа орж оролцдоггүй. Та Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүндэтгэх ёстой. Худлаа юм юу ч яриагүй, худлаа ярьсан байвал та тэрийгээ нотлуул. Би танаас тэрийг харин шаардаж байна. Би Идэрбат гишүүнтэй санал нэг байна.

Та яагаад Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хүрээнд тойргийн сонгогчдын өгсөн тавьж байгаа саналыг энэ чуулганы, Байнгын хороон дээр санал тавихад яагаад болдоггүй юм. Худлаа яриад гэж дээ. Тэгээд та тэр хүндээ хэл л дээ. Би өөр, би өөр хүн шүү дээ. Би бас өөр гишүүн. Та миний юу ярих гэж байгааг урьдчилж мэддэг, тааж мэддэг 5 лам юм уу. Та үг хэлтэй бол бид нар бас үг хэлтэй. Тэгээд сайд дарга гээд та нараас айгаад байна гэж юу байдаг юм. Яана гээд байгаа юм ер нь. Олон удаа наад үйлдэл чинь давтагдаж байна шүү дээ. Та Их Хурлын гишүүдтэй яаж харилцаад байгаа юм. Харин тийм. Тэгэхдээ та сайд, та гүйцэтгэх засаглал. Их Хурлаас томилогдсон. Үгүй тэгээд би худлаа юм юу ярьсан юм. Та тэрийг нотол л доо. Би юмаа ярьж эхлээгүй байхад яагаад худлаа юм ярьсан гээд байгаа юм. Үгүй ээ, санал нэг байна. Санал нэг байна. За санал нэг байна. Тэгээд та миний тэгэхдээ ярьж байгаа зүйлийг урьдчилж таах арга байхгүй.

М.Ганхүлэг: Үгээ үргэлжлүүлье.

М.Бадамсүрэн: Энэ Их Хурлын гишүүний бүрэн эрхэд ингээд болох юм уу Байнгын хороо. Би энэ Байнгын хороонд хуралд үг хэлэх эрхтэй юм уу, эрхгүй юм уу, дурын сайд орж ирээд ингээд загнаад байх юм уу. Их Хурлын гишүүдийг хоёр, гурваар нь. Энэ ер нь зөв юм уу. Юу гэж үзэж байгаа юм энийг Улсын Их Хурал. Үгүй яагаад тойргийн сонгогчдоос тавьсан саналыг ирж уулзсан төлөөллүүдийн саналыг танд уламжилж болохгүй юм. Бид нар тэгээд хэнд уламжлах юм. Энэ зүй ёсны асуудал шүү дээ. Үгүй харин та яриулахгүй байна шүү дээ дундуур дайраад. Үгүй хэн улс төржиж хийрхсэн юм бэ. Тэрийг та яагаад улс төржсөн гэж үзээд байгаа юм. Бид нар ажил хэргийн төлөө л явдаг, тэгсээр ч ирсэн. Зүүн бүсийн гишүүд тойрогтоо хамгийн их ажиллаж, ард иргэдийн санал хүсэлтийг сонсож байгаа. Тэр тэгээд юу нь буруу байгаа юм.

М.Ганхүлэг: Гишүүдийн бас үгийг сонсох нь зөв байх аа. Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ оройн амар амгаланг айлтгая. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хаврын тариалалтынхаа урьдчилсан дүн, бас өвөлжилтийн байдлынхаа талаар тодорхой мэдээллийг ирүүлж, мэдээллээ

танилцуулж байна аа. Би олон юм яримгүй байна. Төрийн бодлого их тогтвортой байх ёстой юм. Тэгж байж бодлогын үр өгөөж үр дүн хангагдах учиртай. Тэгээд энийг бодлогын тогтворгүй байдлаас хамаараад тариалалтын мэдээний чинь бодит байдал энэ тэр ийм л гараад байна л даа. Тийм учраас хэдүүлээ аль болохоор бас нэг энэ улс үндэстний эрх ашгийг бодож, энэ бүхэл бүтэн том салбарыг хооронд нь уялдаатай хөгжүүлэх, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбараа цогцоор нь уялдаатай хөгжүүлэх л ийм л бодлогынхоо төлөө л явах ёстой. Төрийн бодлого энэ тал руугаа тодорхойлогдоод, нааштай үр дүн амжилтууд байгаад байгаа. Гэхдээ бас бидэнд анхаармаар, бодмоор зүйлүүд байгаад байх шиг байна аа. Би бол тэгж бодож байгаа.

Ашигт таримлуудын тухай, ер нь энэ уур амьсгалын өөрчлөлт энэ нөхцөл байдалдаа ахиу бүтээгдэхүүн өгдөг тэр сорт таримлуудыг бид нутагшуулах асуудал дээр илүүтэй онцгой анхаарч ажиллах ёстой болов уу гэсэн ийм бодол байна. Тийм учраас би Ургамал газар тариалангийнхаа хүрээлэнгийн үйл ажиллагааг хэдүүлээ нэг ахиухан дэмжих, ер нь ирэх оны төсөвт болж өгвөл тэр захиалгат, судалгаа, туршилт, үйлдвэрлэлийн чиглэл дээр нь хөрөнгө тавих ёстой байх аа. Тэгж байж энэ нэг Монгол Улсын уур амьсгалд дасан зохицсон таримлуудын үр сортын асуудал зохистой шийдэгдэх болов уу гэж би ингэж бодоод байна. Энэ талаас нэг анхаараач гэдэг нэг ийм зүйл байна.

Хоёр дахь зүйл. Нэгэнт байдал нөхцөл ийм байгаа учраас тооцоо судалгаануудаа нарийсгаж гаргаж ирж эртхэн бэлтгэл зохион байгуулалтуудаа бүрэн хангах тухай асуудал бидэнд байгаад байгаа юмаа. Тийм учраас та хэдийн дутагдал гарах гээд байгаа нөхцөл энэ бүх юмнуудыг бүгдийг нь нэг тооцоо судалгаагаар нь харж, аль болохоор энэ улс орны цаашдын ажил үйлс, энэ ард иргэдийн хүнсний хангамж амьдралд нөлөө үзүүлчихээргүй байх тэр бэлтгэл нөөц зохион байгуулалтыг бид л авах ёстой. Тийм учраас тооцоо судалгаануудаа эртхэн гаргаж, тэр дагуугаа тэр Хүнсний аюулгүй байдлын зөвлөл дээрээ ярьж, квот юмнуудаа зөв тогтоож, тэрийгээ энэ бүс нутгийн онцлогтой нь уялдуулж тогтоох хэрэгтэй байна. Баруун бүс нутгийн гэдэг юм уу, гурил тэжээлийн үнийн өндөр байгаа асуудал яах аргагүй тээвэр ложистиктойгоо холбоотой. Тэрнээс энэ гаалийн татвартай холбоотой юм биш.

Тийм учраас энүүнийг хэдүүлээ тэр богино зайнаас тээвэрлэлт нэг хэсгийг нь хийж, хангаж болдог юмыг нь ч анзааръя. Энэ тээврийн зардлыг бууруулах, сөрөг тээвэрлэлтгүй байх, энэ тээвэр ложистикийн хоорондынх нь уялдааг зөв хангах чиглэл дээр нь ч анхаарч ажиллах тухай асуудал байна. Энэ түгээлтийн сүлжээн дотор өсөлт өгөөд байгаа юмнуудаа бас зөв тогтоож, яаж зохистой, зөв болгох вэ гэдэг юмаа ч хармаар байна.

М.Ганхүлэг: Батжаргал гишүүнд нэг минут нэмье. Нэгэн дээр байхгүй болохоор өгөхгүй байгаад байгаа юм болов уу.

Ж.Батжаргал: Ер нь энэ бэлчээрийн даац тохируулга хийе. Малчдын орлого амьжиргааг нэмэгдүүлье энэ тэр гэвэл сүрэгт хээлтэгчийн эзлэх хувийн жинг нь эрс нэмэгдүүлье. Энэ тооцоо судалгаагаа нэг хийгээч. Хоёрдугаарт, өсвөр малаа эдийн засгийн эргэлтэд оруулдаг энэ нэг туршаад байгаа жоохон нааштай үр дүнгүүдээ бүх нийтийн үйл хэрэг болгож хэдүүлээ аяныг өрнүүлье. Энэ жил харьцангуй өвөл их сайхан орчихсон, мал ер нь нэлээн жилбэтэй байсан. Тийм учраас төлийн ерөнхий жин авалт, торнилт энэ бүх юм их аятайхан байгаа юм байна лээ. Одоо

улсууд өттэй ноцолдох тухай яриад байна. Тэгэхээр энэ жил малчид нэлээн тийм л асуудалтай байх юм байна. Тэгэхээр энэ хургыг намар мах бэлтгэл... асуудлыг тов тодорхой болгomoор байна. Энэ өвөлжилтийн бэлтгэлийг хангахад хамгийн том зүйл. Нэгдүгээрт, малчдыг оролцуулна.

Хоёрдугаарт, хүнд хэцүү цагт өвс тэжээлийн нөөц хэрэгцээг тодорхой хэмжээнд хэмнэх гэдэг юм уу юу гэж хэлмээр юм. Бууруулах бас нэг тийм том боломж нь.

М.Ганхүлэг: Баярлалаа гишүүд асуудалтай холбогдолтой үг хэлж дууслаа. Ажлын хэсгийнхэндээ баярлалаа. Гишүүдийн хэлсэн саналуудыг бас үйл ажиллагаандаа тусган ажиллахыг хүсье. Хаврын тариалалтын үйл ажиллагаатай холбогдолтой асуудлыг хэлэлцэж дууслаа.

Хуралдааны үйл ажиллагааг үргэлжлүүлъя. Эхний асуудал дууссан.

17.24 цаг

Хоёр дахь дахь асуудал байгаа.

Хоёр дахь асуудлаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 13 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэнэ ээ.

Ажлын хэсгийн гишүүдийг, Байнгын хорооны гишүүдийг бас хуралдаандаа орж ирэхийг хүсье. Мөн ажлын хэсгийг оруулъя. Үүний дараа санал хураалттай байгаа тул Байнгын хорооны гишүүдийг орж ирж хуралдаандаа оролцохыг хүсье ээ. Ажлын хэсэг. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийх, Монгол үүлдэр омгийн адууны удмын санг хамгаалах асуудлыг судалж санал дүгнэлт гаргах шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал дүгнэлтийн асуудал байгаа.

Ажлын хэсгийн гишүүд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн Бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга Ц.Мөнхнасан, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Д.Гантулга, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Б.Батбаатар, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал эмнэлгийн хяналт баталгаажуулалтын газрын дарга Батсүх, Татварын ерөнхий газрын бүртгэлийн хэлтсийн дарга Т.Баярмаа, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчдын Анхтуяа, Хөдөө аж ахуйн сургуулийн Мал аж ахуй био технологийн сургуулийн захирал Гүрбазар, судлаач доктор Г.Сувдаа гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байгаа.

Байнгын хорооны дарга түр гарсантай холбогдолтой миний бие Байнгын хорооны үйл ажиллагааг бас чиглүүлээд явж байна. Эхний энэ асуудлыг миний бие танилцуулах байсан учраас шууд эндээсээ танилцуулгаа хийгээд явчихъя аа.

Мөн Байнгын хорооны гишүүдийг ирж саналаа өгч идэвхтэй оролцохыг дахин сануулж хэлье.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 13 дугаар тогтоолоор байгуулагдсан Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийх, монгол үүлдэр омгийн адууны удмын санг хамгаалах асуудлыг судалж, санал дүгнэлт гаргах шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Сайнхүүгийн Ганбаатар, Сонгобайн Замира, Ухнаагийн Отгонбаяр нарын бүрэлдэхүүнтэй ажиллалаа.

Ажлын хэсгийн танилцуулга, санал дүгнэлт, холбогдох шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэн танилцуулж байна аа.

Энэ хугацаанд ажлын хэсэг 4 удаагийн хуралдаан зохион байгуулж, Байнгын хорооны 2025 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан удирдамжийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, Малын тоо толгой, албан татварын талаарх Татварын ерөнхий газрын мэдээлэл, малын генетик нөөцийн хуулийн хэрэгжилт, гаалийн байгууллагын үүрэг оролцооны талаарх Гаалийн ерөнхий газрын мэдээллийг тус тус сонссон.

Түүнчлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газар, Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэн болон Төрийн бус байгууллагын төлөөлөл болох Монголын морин спорт уяачдын холбоо, Монголын үндэсний морин уралдаан уяачдын холбооноос ирүүлсэн саналыг авч, нэгдсэн санал, дүгнэлтэд оруулсан болно. Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг бас байгуулсан. Салбарын яам, холбогдох агентлаг, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын мэргэжлийн холбоод эрдэмтэн судлаачдын төлөөллийг бас Байнгын хорооны гишүүдийн саналын дагуу дэд ажлын хэсгийг бүрдүүлсэн байгаа.

Бид санал дүгнэлтээ 3 агуулгын хүрээнд бэлтгэсэн байгаа. Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлтийн талаарх эхний агуулга байгаа. Монгол Улс 1993 онд Биологийн олон янз байдлын тухай олон улсын конвенцод нэгдэж, Улсын Их Хурал 2017 онд Малын генетик нөөцийн тухай хуулийг баталж, тус хууль 2018 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс үйлчилж эхэлсэн. Хуулийн хэрэгжүүлэх явцад малын генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох, тус нөөцийг ашиглах, судлан хөгжүүлэх, хадгалах хамгаалахтай холбогдсон үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулж иржээ. Тухайлбал малын генетик нөөцийн төлөв байдлыг үндэсний хэмжээнд тодорхойлох, тайлагнах ажлыг салбарын яамнаас 2019 онд зохион байгуулж, үр дүнг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн тайланг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагад хүргүүлжээ.

Энэхүү ажлын үр дүнд Монгол Улс нь малын генетик нөөцөд суурилсан суурилан үндэсний хэрэгцээг хангах, илүү нөөцийг бүс нутгийн болон дэлхийн хүн амын хүнсний хэрэгцээнд нийцүүлэх боломжтойг батлан харуулахын зэрэгцээ Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэх өргөн боломжтойг бататгасан

байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг 2024 онд хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байна аа. Уг үнэлгээгээр хуулийн хэрэгжилтийн биелэлт хангалтгүй, зарим арга хэмжээг эрчимжүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэжээ.

Хоёр дахь үндсэн агуулга нь монгол үүлдрийн омгийн адууны удмын санг хамгаалах асуудлыг судалсан талаар.

Монгол Улсын тухайд малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээг олон улсын аргачлалын дагуу анх 2002 онд хийж, 2019 онд үндэсний хэмжээнд зохион байгуулж, 2020 он НҮБ-ын тэжээвэр мал амьтны төрөл зүйлийн олон улсын мэдээллийн санд Монгол Улсад үржүүлж байгаа 52 үйлдвэр омгийн малын төрөл зүйлийг бүртгүүлсэн. 2024 онд уг бүртгэлийг баяжуулж шинээр үндэсний 7 үйлдвэр омог нутагшуулж буй үйлдвэрийн малын талаарх мэдээллийг бүртгүүлж тайлагнасан. Монгол мал сүрэг нь олон мянган жилийн туршид бүрдсэн популяцын өвөрмөц генетик тогтолцоог хадгалж байгаль цаг уурын эрс тэрс нөхцөл, бэлчээрийн маллагаанд дасан зохицсон онцлогтой юмаа.

Манай улс хонины 27, ямааны 15, үхрийн 6, тэмээний 5, адууны 6, нийт 59 үүлдэр омгийг Үндэсний уугуул үүлдрээр албан ёсоор баталж өсгөн үржүүлж байна аа. Монгол үүлдэр омгийн адуу 2024 оны байдлаар 4.7 сая байгаагаас хээлтэгч нь 37.3 хувь, хээлтүүлэгч нь 3.8 хувийг эзэлж байна аа. Адуун сүргийн ашиглалтын байдлыг авч үзэхэд нийт адуун сүргийн 52.2 хувийг уналга махны, 10.5 хувийг уналга сүүний, 6.5 хувийг хурдны болон спортын чиглэлээр өсгөн үржүүлж байна аа. Харин нийт адуун сүргийн 30.8 хувьд ашиг шимийн чиглэлийг нарийвчлан тогтоох шаардлагатай байгаа талаар Монгол Улсын Малын генетик нөөцийн 2019 оны Үндэсний тайланд дүгнэсэн байна аа. Энэхүү дүгнэлт нь адуун сүргийн популяцын бүтцэд эрсдэл үүссэнийг илэрхийлж байна гэж шинжээчид үзэж байна аа.

Сүүлийн 10 жилийн хугацаанд 23 улсаас Англи, Араб, Ахалтехин Будённый Дон Орлов, Кабирдин Оросын хатирч, Владимирский зэрэг 10 үйлдвэрийн 5209 толгой адууг импортоор авч ашиглажээ. Үржлийн адууг гадаадаас авах тусгай зөвшөөрлийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар 72 иргэн, аж ахуйн нэгж эзэмшиж байна. Малын генетик нөөцийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 92 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А144 дүгээр тушаалаар төрөл бүрийн үүлдэр омгийн малыг үр үржүүлэх, бүс байршлыг тогтоох тухай шийдвэрийн хүрээнд гадаад улсаас сайжруулагчаар оруулж ирсэн цэвэр үүлдрийн адууг тухайлсан бүс нутаг 5 төрлийн малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөөний дагуу үржүүлэх эрх зүйн зохицуулалттай боловч хууль тогтоомжийн шийдвэр практикт хэрэгжихгүй байна аа.

Үүний үндсэн шалтгаан нь энэ чиглэлийн зарим тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үржлийн үнэт чанараар үнэлэгдээгүй удам гарвал нь тодорхойгүй, адууг импортлох улмаар хууль тогтоомжоор тогтоосон бүс нутагт үржүүлэхгүйгээр арилжааны зориулалттай тараах, эрлийзжүүлгийг үржлийн бүртгэл селекцийн хөтөлбөр, мэргэжлийн нэгж мэргэжилтний хяналтгүйгээр үржүүлгийг явуулж, үржлийн сайжруулагч нь тодорхойгүй байгаа үе шатанд эсхүл үр төлөөр үнэлэгдээгүй үржлийн адууг худалдан борлуулах, ашиглуулах явдал ихэссэнтэй холбоотой юм аа.

Мөн үржлийн адууг адуугаар дамжин хил дамнасан малын гоц болон халдварт өвчин эмгэг ялангуяа бэлгийн замын халдварт өвчин тархах эрсдэл ихэссэн. Түүнчлэн хяналтгүй эрлийзжүүлгийн үр дүнд төлийн тэсвэр чанар муудах, өвчинд өртөмтгий байдал ихсэх зэргээр монгол адууны дархлааны системд өөрчлөлт орж байна аа. Мэргэжлийн болон технологийн хяналт, салбар хоорондын уялдаа, зохион байгуулалт хангалтгүй, бүртгэл нэгдсэн системийн солилцоо шуурхай бус байгаа зэрэг нь нийгэмд сөрөг нөлөөлөл үүсгэж байна аа.

Иймээс дараах дүгнэлт саналыг ажлын хэсгээс гаргасан байгаа. Жоохон товчилъё оо. Та хэдэд тараагдсан байгаа учраас. Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлт Монгол үүлдэр омгийн адууны удмын санг хамгаалах асуудлыг ажлын хэсэг судалсны үндсэн дээр дараах дүгнэлт саналыг гаргаж байна.

Нэгд, Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн биелэлт хангалтгүй байгаад 1 дүгээрт хуулийн хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр төсөв бүрдэхгүй байна. 2 дугаарт хуулийн хэрэгжилтэд хяналт тавих мэргэжлийн бүтэц зохион байгуулалт сул, хүний нөөцийн хангамж хүртээмжгүй, 3 дугаарт малын генетик нөөцийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдэхгүй байгаа. 4-т хуулиар заасан зарим чиг үүргийг хэрэгжүүлэхгүй байгаа зэрэг хүчин зүйлс нь нөлөөлжээ.

Улс орон бүр өөрийн байгаль экологийн онцлог, технологийн горимд дасан зохицсон үндэсний уугуул гино хэвшлийн малыг өсгөн үржүүлэх бодлогыг баримталдаг боловч манай улсад байгаль экологийн технологийн өөр өөр нөхцөл бүхий улс орнуудаас удамшлын шинж тэмдэг, ашиг шимийн чиглэлийн хувьд ялгаатай адууг импортлон үржилд ашиглах болсон нь монгол адууны популяцын генетикийн тэнцвэрт байдалд өөрчлөлт оруулахуйц геноцит эрсдэлийг дагуулж байна аа.

Салбарын яам холбогдох шинжлэх ухааны байгууллага, судалгаа, тайлан, салбарын судлаачид, мэргэжлийн холбоодын төлөөлөл, малчид, орон нутгийн уяачдын санал дүн шинжилгээнд үндэслэн Монгол Улсын хилээр гадаад улсаас оруулах үржлийн адууны адуу түүний хөврөлийн тоо хэмжээг 2026 оноос эхлэн тодорхой хугацаанд хязгаарлах нь зүйтэй гэж дүгнэлтийг ирүүлсэн байгаа.

Ингээд цаашид хэрэгжүүлэх тодорхой асуудлуудыг энд тусгасан байгаа. Ингээд дээрх дүгнэлт саналыг үндэслэн малын генетик нөөцийг хамгаалах чиглэлээр зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлийг Засгийн газарт хүргүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Малын генетик нөөцийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан танилцуулж байна.

Тус тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүнд баярлалаа. Санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? нэрсээ өгнө үү? Батжаргал гишүүнээр тасалъя. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя. .

Б.Бат-Эрдэнэ: Их сайн, нийгэмд нөгөө аягүй сайн ойлголт л өгөх ёстой юм шиг зүгээр надад санагдаад байгаа юм. Би одоо сайн морь мэдэхгүй л дээ, үнэнээ

л хэлье. Компьютероо бол илүү мэдэх байх. Зөвхөн хурдан морины асуудал яриад байна уу, эсвэл ерөөсөө л мориныхоо монгол мориныхоо тухай яриад байна уу? Би өнгөрсөн нөгөө Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байхад Солонгост нэг айлчлалаар явж байхад тэднийх солонгос морь гээд надад нэг морь танилцуулж байсан юм. Тэр нэг Кёнжү ч билүү, хаана ч билээ нэг морин уралдаан байдаг. 1.8 км, 1.6 км, 1.2 км-тэй. Тэгээд Жүчэ энэ тэртэй бооцоот морь юм билээ. Морь уралдаан юм билээ. Тэгээд очоод ингээд хараад ярьж байхад нөхдүүд бол манай солонгос морь гээд надад танилцуулаад би тэгээд жоохон инээгээд, үгүй ээ танай солонгос морь гэж юу байдаг юм бэ? Монгол морины тухай ярихад ойлголт бол болохоос солонгос морины тухай ойлголт байхгүй гэсэн чинь уучлаарай сайд аа, манайхан ингээд 100 жилийн өмнөөс манайх 100 жилийнхээ ойг тэмдэглэсэн. 100 жилийн өмнөөс солонгос морь гаргаж авахаар болоод ингээд явсаар байгаад бид нар ийм богино зайн уралдааны солонгос морь бид нар гаргаж авсан. Энийгээ бид нар бүртгүүлчихсэн. Энэ бол солонгос морь гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр нь би нөгөө талдаа тэгвэл монгол морь ямар байгаа юм гэсэн. Танай монгол морь чинь байгаа. Манай Чэжүд байна, одой морь гэж байгаа юм. Манай хэллэгээр бол одой морь гэж ярьж байгаа юм. Тэгээд ирээд би нөгөө ганц 2 хүмүүстэй уулзаад ингээд үгүй энэ монгол морь гэж яг бүртгэл байна уу? Одоо бид нар чинь нэг мянган бөх гээд л ингээд нэг баахан бүртгүүлээд л байдаг шүү дээ. Гиннесийн номд бүртгүүлээ гээд л бөөн юм болоод л байдаг. Морин уралдаан нь яг өнөөдөр манайх дээр байгаа юм уу, байхгүй юм уу?

Морин уралдаан нь манайх дээр байгаа юм уу, байхгүй юм уу гэдэг ч юм уу. Одоо ний нуугүй хэлэхэд нөгөө насанд хүрээгүй хүүхдүүдийг морь унуулахгүй гэсээр байгаад тэр хүүхдүүд чинь уяач нартайгаа цуг бараг ихэнх нь Өвөр монгол руу гараад явчихлаа шүү дээ. Тэнд яг жинхэнэ утгаараа аялал жуулчлалын маш том контентууд, концепцууд, морьтой холбоотой юмнууд тэнд өрнөж байна. Тэгэхээр бид нар би зүгээр сайн мэдэхгүй гэдгээ түрүүн хэлсэн учраас монгол морь гэдэг бүртгэл байна уу? Яг албан ёсны бүртгэл. Одоо бид нар ингээд сая ярьж байгаад Ганхүлэг гишүүний уншсан зүйлээс сонсохоор ингээд л баахан бэлгийн замын өвчлөл гээд л байдаг юм байна. Ингээд л баахан халдвартай, халдваргүй баахан өвчнүүд байдаг л юм шиг байна. Тэгээд яг энэ удмын сандаа юу гэж бүртгүүлсэн байдаг юм?

Дэлхийд бид нар монгол морь гээд л дэлхийн талыг эзэлсэн л гээд л нэг юм яриад л байдаг, яриад л байдаг. Яг энэ дээрээ монгол морио бүртгүүлчихсэн генийн судалгааг нь хийчихсэн албан ёсоор баталгаажуулсан яг ийм юм байдаг юм уу гэдгийг би асуух гэж байгаа юм. Байдаг бол гаднаас орж ирж байгаа, оруулахыг нь хориглоод байгаа тэр моринууд чинь азарга нь байдаг юм уу, юу нь байдаг юм орж ирээд тийм их хэмжээний өөрчлөлт орчихоор хэмжээний нөлөөлөл үзүүлээд байгаа юм уу гэдэг хоёр...

Б.Бейсен: Ажлын хэсэг Ганхүлэг гишүүн асуултад хариулъя.

М.Ганхүлэг: Бас манай одоо ажлын хэсгийн гишүүд нэмэлт хариулт өгөх байх аа. Ажлын хэсгийн хүрээнд судалгааны судлаад ингээд ажиллаж байхад Монгол Улсад бүртгэлтэй адууны 3 үүлдэр байна аа. Энийгээ бид бүхэн баталгаажуулаад, олон улсынхаа тайландаа оруулаад ингээд явж байгаа. 3 омог байгаа. 3 үүлдэр дотроо бол Монгол Тэс, Галшар одоо үндсэндээ үүлдрүүд байна. Омгуудын хувьд Дархад, Өндөршил, Мянгад гэсэн ийм омгууд байна аа. Тэгэхээр манай Хүнс, хөдөө аж ахуйн яамны харьяа судлаачдын үндсэндээ багууд бол энэ

малын үүлдэр угсааг тодорхойлох баталгаажуулах энэ ажлуудыг зохион байгуулдаг. Тэгэхээр албан ёсоор бүртгэлтэй ийм 3 үүлдэр байна аа.

Цаашдаа бид бүхэн энэхүү асуудлыг оруулж ирж байгаатай холбогдолтой тодорхой судалгаануудыг хийгээд ингээд ажиллаж байгаа юмаа. Сүүлийн 10 жилийн хугацаанд бид нар импортоор 5 мянга гаруй үндсэндээ үржлийн адууг оруулж ирсэн байгаа юмаа. Үүнтэй холбогдолтойгоор өнөөдөр гарч байгаа олон эрсдэлийн тухай би сая үндсэндээ танилцуулгууддаа хэллээ. Зөвхөн энэ морин уралдаантай холбогдолтой асуудал энэ бол бас гэж харж болохгүй ээ. Үүний цаана монгол адууны удмын сан бид нар бүхэн таны яг хэлж байгаа өөрийн бүс орон нутагтаа зохицсон энэ байдлаар нь үндсэндээ үүлдэр угсаагаа авч үлдэхтэй холбогдолтой асуудал байгаа юмаа. 2019 оноос ер нь 2017 онд бид нар хуулиа батлаад, 2018 оны 6 сарын 1-ээс эхлээд хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хууль үндсэндээ батлагдсанаараа 2019 онд бид нар НҮБ-д өөрсдийн үндсэндээ энэ үүлдэр угсаатай холбогдолтой тодорхой энэ тайлан мэдээллүүдийг 3 жил тутам хүргүүлэх ийм боломжтой болсон. Хамгийн сүүлд 2019 онд бид бүхэн энэхүү тайлангаа гаргасан. Үүнээс хойш нарийн судалсан мэдээлэл юмнууд бол хомс байгаа.

Тийм учраас тогтоолын болон дүгнэлтийн маань хамгийн чухал хэсэг дээр бид нар өөрсдөө энэ үүлдэр угсаатай холбогдолтой энэ асуудлаа 3 жил тутам үнэлдэг энэ хуулийн хэрэгжилтийг хангах шаардлагатай байна гэдэг энэ агуулгыг оруулж ирж байгаа юмаа. Тэгж байж бид нар цаашдаа аль төрлийн үүлдэр угсааг аль бүс нутагт нь илүү сайнаар хөгжүүлэх вэ гэдэг асуудлууд яригдана аа. Хамгийн энгийнээр үндсэндээ 2019 оны энэхүү судалгаа тооцоололд ингээд харахад Монголд байгаа 3 адуу тутмынхаа бид нар нэгийг нь яг ямар ашиг шимтэй, ямар үндсэндээ чиглэлээр үржүүлж байгаа вэ гэдгээ тодорхойлж чадахгүй байгаа. Тэгэхээр үндсэндээ энэ 30.8 хувийн энэ ашиг шимийн нөхцөл байдлыг тодорхойлж чадахгүй байгаа байдал 2019 оноос хойш бүр л нэмэгдэж байгаа. Тэгэхээр энэ хяналтгүй явж байгаа үржүүлгийн ажлууд тодорхой хүнтэй холбогдолтой асуудлуудыг зайлшгүй авч хэрэгжүүлэхтэй холбогдолтой тодорхой санал дүгнэлтүүдийг тогтоолын төсөл дээр тусгасан байгаа.

Олон улсын түвшинтэй холбогдолтой нэмэлт мэдээллийг ажлын хэсгээс манайхнаас өгөх нь зөв болов уу гэж бодож байна. Сувдаа доктор.

Б.Бейсен: 3 номер Сувдаа дарга хариулъя. 4 номер Сувдаа дарга.

Сувдаа: Батбаатар гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье өө. Ер нь дэлхийн хэмжээнд бол нэг 8 мянга гаруй үүлдрийн мал амьтан байна гэж олон улсын НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас бол тайлагнаж гаргасан байгаа. Үүнээс бол адууны бол нэг 400 үүлдэр байгаа юм. Манай улсын болоод ер нь олон улсын түвшний үнэлгээний аргачлал бол ижил явж байгаа. Нэгдүгээрт бол нийт тухайн популяц зүйлийнхээ хувьд бол устсан уу, эрсдэлтэй байгаа юу, эрсдэлгүй байгаа юу, эсвэл тодорхойгүй байгаа юу гэсэн ийм 4 ангиллаар явж байгаа. Тэгэхээр олон улсын түвшинд адууны бол эрсдэлийн түвшний үнэлгээгээр бол дэлхийд нийт адууны популяцын 11.5 хувь устчихсан гэсэн хамгийн сүүлийн үеийн тайланд гарсан байгаа. 22.6 хувь нь...

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Г.Сувдаа: 31.8 хувь нь эрсдэлгүй, 34.1 нь тодорхойгүй ангилалд байгаа юм. Тэгэхээр манай улсын үнэлгээгээр бол энэ 30.8 хувь нь энэ тодорхойгүй статустай гэдэг ангилалд орчихсон байгаа учраас энэ угаасаа эрсдэл үүсчихсэн байна гэж үзэж байгаа. Энэ тэгэхээр олон улсын аргачлалынхаа дагуу. Генетик тогтолцооны өөрчлөлтийн хувьд бол бид нар бол ерөнхийдөө монгол адууг бол НҮБ-ын тэжээвэр мал амьтны олон улсын бүртгэлийн санд албан ёсоор 2020 онд бол бүртгүүлсэн байгаа. Ромд байдаг энэ бүртгэлийн мэдээллийн санд. Дараа нь бол 2025 онд баяжуулалтыг хийж нэмж тайлагнасан байгаа. Монгол адууны генетик тогтолцоо популяцын энэ генийн дэс дарааллын хувьд бол монгол адуун дээр бол ОХУ болоод энэ бусад улс орны тухайлбал Солонгосын сүүлийн үед бол яг генетик генийн бол шинжилгээнүүдийг хийгээд ялгаатай өвөрмөц байдлыг нь бол тогтоогоод явж байгаа...

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Би нөгөө нэг асуугаад байгаа нь нэг ингэж л асуугаад байгаа юм. Яг энэ монгол адууны унаган үүлдэр гэж яг юуг хэлээд байгаа юм бэ? Ямар стандарт байдаг юм бэ? Яг монгол адуу гэж байгаа юм уу л гэж би асуугаад байгаа юм. Үгүй яг тэрийг л асуугаад байгаа юм тийм.

Б.Бейсен: 5 номер хариулъя.

Ц.Мөнхнасан: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Бат-Эрдэнэ гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Монгол үүлдрийн сая гишүүдийн ярьж байгаа 3 омог, 3 үүлдрийн адууг тодорхойлдог монгол үүлдэр омгийн адуунд тавигддаг ерөнхий шаардлага, MNS 4099 2020 гэж стандарт байж байдаг. Энэхүү стандартад өчигдөр Хөдөө аж ахуйн техникийн стандартчиллын техникийн хорооны хурлаар ороод нэмэлт, өөрчлөлт ороод өнөөдрөөс эхлээд монгол үүлдрийн омгийн адуунд тавигдах ерөнхий шаардлага MNS 4099 2025 гэдэг стандартаар тодорхойлохоор байгаа. Монгол Улсад монгол адуу бол байна аа.

Б.Бейсен: Батжаргал гишүүн асуулт асууя. Отгонбаяр гишүүн ажлын хэсгийн гишүүн хариулъя.

У.Отгонбаяр: Сая Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа бол үнэн. Энийг бид бүхэн олон нийтэд маш зөв ойлгуулах ёстой юм билээ. Энэ мэдээ мэдээллээ маш сайн өгөх ёстой юм билээ. Одоо тэр дундаа бид бүхэн яагаад энэ Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтэд хэрэгжилтийг хяналт тавьж санал дүгнэлт боловсруулах энэ ажлын хэсэг байгуулагдсан гэвэл өөрөө энэ цаг мөчид энэ эдийн засаг хүнд байгаа, гадаад, дотоод нөхцөл байдал хүнд байгаа энэ цаг мөчид бид бүхэн энэ дээр бас нэг тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх ёстой юм билээ. Зүгээр нэгхэн эдийн засаг талаас нь нэг зүгээр жишээ хэлэхэд үндсэндээ сүүлийн 10 жилийн байдлаар ингээд аваад үзэхээр жилдээ нэг 500 орчим адуу орж ирж байгаа юм гаднаас. Энэ нь голцуу хурдны чиглэлийн азарга орж ирж байгаа. Нэг дунджаар сүүлийн 10 жилд 500 орж ирсэн. Тэгээд судалгааг нь аваад...

Б.Бейсен: Отгонбаяр гишүүн гүйцээж хариулъя. Сая 3 минут арай болоогүй байх аа тиймээ.

У.Отгонбаяр: Тийм тэгээд эдийн засаг талаас нь аваад үзэхээр жилдээ 500 адуу, хамгийн багадаа 50-250 сая төгрөгийн үнэ бүхий азарга адуу орж ирж байгаа

юм. Тэгэхээр энэ бол жилдээ нэг хамгийн багадаа нэг 70-80 тэрбум төгрөг. Энийг дагасан тэжээл овъёос энэ чинь тусгай юмаар мэдээж тэжээнэ шүү дээ. Энийг дагасан эмнэлгийн хэрэгсэл, эм бэлдмэл гээд маш эдийн засгийн хувьд энэ нэг жилдээ бараг хамгийн багадаа 150 орчим тэрбум төгрөг зөвхөн энэ импортын адуунд гадагшаа гарч байгаа ийм тоон үзүүлэлт жишээ нь байгаа юм. Тэгээд нөгөө орж ирсэн 500 адуу чинь хамгийн багадаа нэг азарганд 20 гүү, энэ 20 гүү гэдэг 500-г ингээд 20-иор ингээд тооцоод үзэхээр хамгийн багадаа нэг мянган... манай ажлын хэсэг хэлж байна шүү дээ. Энэ чинь тодорхойлж байгаа 30 хэдэн хувь нь маш тодорхойгүй нөхцөл байдал руу очсон. Тийм учраас бид бүхэн энэ дээр ажлын хэсэг байгуулж, нэг тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлбэ гэж ажиллаж байгаа.

Б.Бейсен: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Үгүй энэ генетик нөөц гэж ер нь яг биднүүс нэр томъёоллоороо юу гэж тодорхойлсон билээ? Ашиг шимийн үзүүлэлт талаасаа хуулийн томъёолол дотроо нэршил дотроо оруулчихсан шиг санаад байх юм би. Үгүй тэгээд хэдүүлээ ямар байдлаар асуудалд хандах вэ гэдэг юм гарч ирээд байна л даа наадах чинь. Би бол угаасаа байгаль цаг уурдаа дасан зохицсон тэсвэрт чанартай энэ малаа хадгалах тухай асуудал руу онцгой анхаарах ёстой юм гэж. Угаасаа биднүүсийн том зорилт тэр. Энүүнийг хэрвээ тэгж хадгална гэвэл бидэнд их олон зүйл гарч ирдэг юм аа. Наад Үндэсний баяр наадмын тухай хууль дээр чинь адуу сайжруулж болно оо. Тэр нь улсынхаа наадамд тэр тусгай ангиллаараа уралд аа. Сумын наадамдаа бол жинхэнэ тэр биднүүсийн ярьж заншсанаар монгол адуу нь уралдаг ээ, тэгж байж наад хөдөөгийн малчид чинь нэг байгаль цаг уурынхаа эрсдэлийг даадаг, тэсвэр чанартай, малтайгаа үлдэг ээ гэж ингэж зохицуулж оруулж өгсөн. Энүүнийг барьж байгаа газар байхгүй юм байна лээ.

Уг нь бол энэ чинь хэмжээс хийгээд үүлдэрлэг байдлыг нь харж байж сумын наадамд уралдах ийм хуулийн зохицуулалттай. Одоо мөрдөгдөж байгаа хууль чинь. Харин Үндэсний баяр наадмын тухай хуульд энэ оны баяр наадмаас эхлээд тэр яг та нарын лабораторийн гэдэг юм уу, удам гарвал үүслийнхээ тодорхойлолтоор энэ бол яах аргагүй монгол адуу гэдэг юм уу энэ юм нь тогтоогдсон адуу уралдахаар заасан. Энэ бэлтгэл ажил ер нь хэрхэн хангагдсан юм бэ улсын хэмжээнд. Одоо наадам бараг үндсэндээ сар хүрэхгүй хугацааны ард дээр болох гэж байна аа. Энүүнийг ер нь ямархуу байдлаар анзаарч байна вэ гэж нэг ийм зүйл байгаад байгаа юм.

Яах вэ бид үржлийн адуу үр хөврөл үржлийн бүтээгдэхүүн оруулж ирэхгүй тухай зааж байна. 2036 он хүртэл. Гэтэл газар тариалангийн салбарт чинь махны чиглэлийн адуу оруулж ирээд хөгжүүлж байгаа улсууд байна аа. Хурдны биш ээ, махны. Энэ хүн амын өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэгцээ, дээр нь адууны өөрийнх нь тэр байгалийн давтагдашгүй нөхцөл дээр нь тулгуурлаад байх шиг байгаа юм. Янз бүрийн өвчин эмгэг давамгайлж тээдэггүй, зах зээлд эргэлзээгүйгээр бүтээгдэхүүн борлодог гэдэг үүднээс магад ч үгүй махны чиглэлийн адууг энд үржүүлж, өсгөж гадаад зах зээл рүү гаргах гэсэн ийм хүсэл тэмүүлэл байх шиг байна гэж. Тэрүүнийгээ хэдүүлээ яаж ялгаж авч үлдэх юм бэ? Юу гэж тооцоод байна аа?

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 4 номер, 5 номер.

Ц.Мөнхнасан: Батжаргал гишүүний асуултад хариулъя аа. Тэгэхээр ер нь малын генетик нөөц гэж Малын генетик нөөцийн тухай хууль дээр мал түүний үржүүлгийн бүтээгдэхүүн болон тэдгээртэй хамааралтай уламжлалт мэдлэгийг хэлнэ гэж тодорхойлж заасан байгаа. Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах тухай хуулиар 2025 оны 6 дугаар сарын 1-ний дотор монгол үүлдрийн адууны стандартыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бусад холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран боловсруулж батлуулах үүрэгтэй. Энэ үүргийнхээ дагуу монгол адуу нь монгол үүлдрийн омгийн адуунд тавигдах ерөнхий шаардлага, MNS 40 99 2020 гэдэг стандартыг шинэчлээд монгол үүлдрийн адуунд тавигдах ерөнхий шаардлага, MNS 4099 2025 гэж стандартыг батлуулсан. Одоо энэхүү стандарт батлагдсанаараа баяр наадмыг зохион байгуулах Үндэсний хороо энэ стандартыг хэрэгжүүлж ажиллах тухай Засгийн газрын 2022 оны 257 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж заах учиртай. Ингэснээр энэхүү стандарт улсын, аймгийн, сумын баяр наадамд мөрдөгдөх ийм боломж бүрдэнэ. Стандарт бол зөвлөмжийн шинж чанартай баримт бичиг. Захиргааны хэм хэмжээний акт дээр тусгагдсанаар заавал мөрдөх баримт бичиг болж хувирна аа.

Ийм учраас Стандарт, хэмжил зүйн газраас стандартын батлуулсан төслөө баяр наадмыг зохион байгуулах салбар хороонд хүргүүлэх юмаа. Ингэж одоо монгол наадамд монгол адуу уралдах бэлтгэл хангагдаж байна аа. Энэхүү Улсын Их Хурлын тогтоолын төслийн 3 дугаар заалтаар үржлийн адуу түүний үр хөврөлийн импортыг тодорхой хугацаанд хязгаарлах асуудал яригдаж байгаа. Энэ хязгаарлалтаар бол зөвхөн хурдны адууны асуудлыг ярихгүй байгаа. Монгол үүлдэр омгийн адууны генетик нөөцийг хамгаалах, хадгалах чиглэлд яригдаж байгаа учраас бид зөвхөн хурдны чиглэлийн үржлийн адуу оруулж ирэхийг хязгаарлаад махны зориулалттай үүлдэр омгийн адууг оруулж ирэхийг нээлттэй орхих юм бол магадгүй эргээд хэдэн жилийн дараа бид нар нөгөө монгол адуу маань хурдны чиглэлээр сайжруулагдахаас гадна эргээд махны чиглэлээр сайжруулагдаад бид нарын өнөөдөр яриад байгаа ашиг шимийн үзүүлэлт нь тодорхойгүй байгаа 30.8 хувь маань улам нэмэгдэх ийм эрсдэл байна гэж ингэж бас харж байгаа.

Б.Бейсен: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Хууль батлагдаад энэ чинь 3 дахь жилдээ орж байгаа билүү? Би тэгж санаад байх юм. Үндэсний баяр наадмын тухай хууль үгүй тэгээд та хэд наадам болох гэж байхад ерөөсөө нэг 20 хоног үлдчихээд байхад өчигдөр стандартаа 25 стандартаа батлахаар залгуулаад наадхыг чинь дагаж гардаг шийдвэрүүд нь хэзээ гарч энэ жилийн наадам чинь явах юм. Энэ төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх юм уу, хэрэгжүүлэхгүй юм уу. Үндсэндээ би үхэхээс ч үх гээд өөрсдөөсөө холдуулаад нэг стандарт батлаад хаяж байгаа байхгүй юу. Наадах чинь бөөн хэл ам болно. Монгол адууны тэр 20, 25 гэсэн тэр стандартыг чинь адуун дээр нь юугаар нь тогтоох юм? Ямар ч байсан хэмжээс үүлдэрлэг байдал хоёр нүдэн баримжаагаар нэг хардаг юм байж. Тэгээд хэрүүл нь үүсээд нотолгоо нэхнэ шүү дээ. Тэгэхээр юугаар нь тогтоох юм.

Б.Бейсен: Батжаргал гишүүн гүйцээж асууя.

Ж.Батжаргал: Тийм энэ асуудлаа нэг тодорхой болгож, энэ улсуудыг хэрүүлгүй нэг баярлуулах юм сан даа хэдүүлээ. Нэг энэ асуудал ер нь нэлээн тийм чухал асуудал байна. Би энэ талаас нь асуудалд хараад байна.

Дараагийн нэг асуудал байгаад байгаа юм. Та хэд тэр стандарт батлаад гэдэг юм уу, омог тогтоогоод л явахаар зэрэг энэ. Ер нь манай мэргэжлийн байгууллагаас гэхээсээ илүүтэйгээр малчид чинь бараг онцлогоо тогтоочоод байгаа юм биш үү? Яагаад энэ зүүн талын адуу хурдан байна гээд судлахаар зэрэг ерөөсөө газар зүйн байршилтайгаа холбоотой юм байна аа. Энэнээсээ хамаараад тэр ясны бүтцийн тогтолт нь дагаж бий болдог юм байна. Тийм учраас бараг туураар илүү алхаад явчихдаг юм байна. Тийм адуу...

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 5 номер.

Ц.Мөнхнасан: Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах тухай хууль дээр стандарт батлангуут шууд баяр наадмын хороо хуралдаад шийдвэрээ гаргах ийм зохицуулалт нь байж байгаа. Хэрхэн, яаж нотлох юм бэ гээд Батжаргал гишүүнтэй санал нэг байна аа. Одоо өнөөдрийн байгаа бид нарын ярьж байгаа MNS 4099:2025 гэдэг стандарт бол монгол үүлдрийн омгийн адууг зөвхөн гадаад шинж тэмдгийн хувьд тодорхойлж байгаа юмаа. Зөвхөн гадаад шинж тэмдгийн хувьд тодорхойлж байгаа юм. Үндсэн биеийн хэмжээсээр 4 үзүүлэлтээр тодорхойлж байгаа юм. Сэрвээний өндөр, шилбэний бүслүүр, цээжний бүслүүр, биеийн ташуу урт, амьдын жин тэгээд дээрээс нь сүүний гарц гэсэн үндсэн гадаад шинж тэмдгээр нь тодорхойлж байгаа юм. Дотоод шинж тэмдэг буюу генетик шинжээр нь тодорхойлох гэхээр бид нарт тодорхой судалгаа...

Б.Бейсен: 5 номер гүйцээж хариулъя.

Ц.Мөнхнасан: Гений дараалал тогтоох, эдгээр судалгаа шинжилгээний ажлуудыг хийх цаг хугацаа шаардлагатай байна. 2022 онд энэ чиглэлийн ялангуяа хурдан адууны гений монгол адууны гений дараалал тогтоох чиглэлээр 1200 орчим адууны цусны дээж аваад судалгааг эхлүүлсэн боловч санхүүгийн хүрэлцээгүйгээс болоод өнөөдрийн байдлаар бид нарт 1200 адууны цусны дээж хадгалагдсан хэвээр байна аа. Тухайн үед Солонгос улсын Малын генетикийн лабораторид шинжлүүлэх төлөвлөгөөтэй байсан боловч тэрийгээ шинжлүүлж чадаагүй байгаа. Энэхүү арга хэмжээг хийж заавал монгол адууны гений дарааллыг тогтоосон тохиолдолд Монгол Улсын болон энэ аймаг, сумын наадамд уралдаж байгаа монгол адууны ялгаж тогтооход маргаангүй. Тэгээд шинжлэх ухааны үндэслэлтэй хялбар ийм болох бүрэн боломж байж байгаа.

Б.Бейсен: Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Энэ малын яг энэ генетик нөөцтэй уялдуулаад энэ монгол адууг удмын санг хадгалах энэ асуудал их чухал юмаа. Бид нар ганцхан мал аж ахуйн салбар гэхээсээ илүүтэй үндэсний бахархал биологийн бид нар баялаг болж байгаа энэ монгол адууг хадгалж үлдэх, хамгаалах гэдэг нь өөрөө маш чухал асуудал учраас энийг 100 хувь дэмжиж байгаа. Тэгээд ажлын хэсгээс хэдэн асуулт байна аа. Энэ ямар ч байсан нөгөө Малын генетик нөөцийн тухай хуульд зааснаар 3 жил тутам судалгаа хийдэг 6 жил хийгдээгүй байгааг одоо бол энэ хийхээр төлөвлөж байгаа юм байна тийм үү. Тэгэхлээр энэ судалгаа дээр үндэслээд Монгол Улсын одоо энэ 50 гаруй үүлдэр омгийн малын жагсаалт тэр Ромд бүртгэлтэй байдаг гэсэн. Одоо бид энэ судалгаагаар хамгаалж үлдээд энэ нэмж шинэчлэх төлөв байдлын өөрчлөлтийг оруулах энэ асуудал хийгдэх үү гэж нэгдүгээр асуулт.

Хоёрт нь, одоо энэ малын чанарыг сайжруулахад ялангуяа энэ адууны үүлдэр угсааг сайжруулахад яг ямар арга хэмжээ тусгагдаж байгаа юм бэ гэдэг дээр мэдээлэл авъя.

Гуравдугаарт бүсчилсэн хөгжлийн бодлогод бодлого нөгөө бүсчилсэн хөгжлийн бодлогод бүс болгонд цөм сүргийн аж ахуйг дэмжихээр заасан байгаа. Тэгэхлээр үүнтэй уялдуулж ямар ажил яг энэ ажлын хүрээнд хийгдэх юм бэ гэдгийг тодруулъя. Мөн монгол адууны удмын санг алдагдуулахгүйн тулд ямар тэгээд хяналтын тогтолцоог үүгээр бий болгох юм бэ? Бид нар яаж энийг хянах юм тиймээ. Энэ одоо хяналтын тогтолцоог яаж хэрэгжүүлэх гэж байгаа вэ гэдэг асуултыг асууя.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 5 номер хариулъя.

Ц.Мөнхнасан: Мандхай гишүүний асуултад хариулъя аа. Тийм ээ, 3 жил тутамд хийгдэх ёстой малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээний ажил 6 жилийн хоцрогдолтой явж байгаа учир хоцрогдолтой явсан учраас шалтгаан бас байна аа. Зовлон бэрхшээл байсан. Засгийн газрын тогтоолоор малын генетик нөөцийн төлөв байдлын судалгааг хийхэд малын төрөл тус бүрээр тодорхой тариф буюу хийх судалгааны зардлыг баталсан. Нэгжийн зардлыг батлаад өгчихсөн. Энэ маань 2019 онд батлагдсан. Түүнээс хойш инфляцын өсөлт гээд одоо тэр батлагдсан норм норматив, нормативын дагуу олгогдсон санхүүжилтээр үнэлгээ хийх үнэхээр боломжгүй болсон. Энэ тогтоолын хүрээнд бид бүхэн нэгжийн үнэ норм нормативаас цэгцэлж байгаад 6 жил хийгдээгүй тасарсан байгаа малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээг хийнэ ээ. Энэхүү үнэлгээг хийснээр малын генетик нөөцөд буюу энэ төлөв байдалд нь хэрхэн ямар өөрчлөлт орсон тухай үндэсний тайланг гаргаж, олон улсдаа хүргүүлнэ ээ.

Энэний хүрээнд зөвхөн одоо малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээ хийгдээд зогсохгүй цаашдаа малдаа үзлэг ангилалд хувьслын бөгөөд ангийн үзлэг ангилалтуудыг хийх ёстой. Үзлэг ангилалтуудын үр дүнд мал сүрэг маань хэдэн хувь нь цөм сүрэг юм, хэдэн хувь нь гойд ашиг шимт, хэдэн хувь нь үржлийн, хэдэн хувь нь таваарын сүрэгт ангилагдсан бэ гэдгээс хамааруулаад тухайн төрөл төрлийн тухайн үүлдэр омгийн мал бүрд тохирсон үржүүлгийн хөтөлбөр гэдгийг боловсруулж батлах ёстой юмаа. Эдгээр үржүүлгийн хөтөлбөрүүдийг тухайн цөм сүргийг өсгөн үржүүлж байгаа аймаг, сумын Засаг даргын тамгын газрын оролцоотой малчид иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх ийм боломж бүрдэнэ ээ. Яг өнөөдрийн байдлаар Монгол Улсын 5 төрлийн малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөө гээд ерөнхий төлөвлөгөөгөөр явж байгаа.

Сүүлийн үед одоо омог үүлдрээр батлагдаж байгаа мал бүр дээр үржүүлгийн хөтөлбөр байгаа. Энэ үржүүлгийн хөтөлбөр хэрхэн хэрэгжиж байна вэ? Одоо батлагдах хувийнхаа ашиг шимийн үзүүлэлтээ сайжирсан байна уу, муужирсан байна уу гэдэг үнэлгээнүүд сая бид нарын ярьдаг төлөв байдлын үнэлгээ, үзлэг ангилалтын үр дүнд тодорхой болно. Эдгээр одоо судалгаа, шинжилгээний ажлуудыг хийж байж цаашдаа тухайн төрөл ангиллыг хэрхэн яаж үржүүлэх тухай стратеги төлөвлөгөөнүүд нь боловсруулагдах учиртай. Эдгээр чиглэлийн арга хэмжээнүүд арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгоод энэхүү тогтоолоор оруулж өгч байгаа юм аа.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг өнгөрсөн онд шинэчлэн баталсантай холбоотойгоор бүс бүрд орон нутгийн онцлогт тохирсон цөм

сүргийн үржлийн аж ахуйнуудыг байгуулахаар заасан байгаа. Өнөөдрийн байдлаар манай Засгийн газрын тогтоолоор 13 байршилд монгол үүлдэр омгийн малын цөм сүрэг байршиж байгаа. Эдгээр нь бүгдээрээ төрийн өмчит цөм сүрэг буюу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Малын удмын сангийн үндэсний төв дээр бүртгэлтэй явдаг 13 цөм сүрэг байх учиртай юмаа. Энэхүү бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал шинэчлэн батлагдсантай холбоотойгоор эдгээр 13 байршилд байгаа төрийн өмчийн цөм сүргийн малыг одоо бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулж Засгийн газрын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах ажил яг өнөөдрийн байдлаар хийгдэж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар ажлын хэсэг гараад төрийн өмчийн цөм сүргийн тоо бүртгэл, ашиглалт, хамгаалалт үйлдвэрлэх байдал зэрэг дээр нь хяналт шалгалт бол хийгдсэн. Ингэхээр хяналт шалгалтын үр дүн...

Б.Бейсен: 5 номер гүйцээж хариулъя.

Ц.Мөнхнасан: Эхний байдлаар одоо хяналт шалгалтын үр дүн гарсан байна. Ер нь Монгол Улсын төрийн өмчийн цөм сүргийн үйлдвэрлэг байдал, чанар тодорхой түвшинд алдагдсан байна гэдэг анхны дүгнэлт гарчихсан байна аа. Тэгэхээр энэхүү дүгнэлтийг үндэслээд Засгийн газрын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулаад бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулаад нэг 4-6 байршилд тодорхой зөвхөн одоо Монгол орны байгаль цаг уурын онцлогт дасан зохицсон тэсвэр чанар сайтай монгол үүлдрийн малыг төрийн цөм сүрэг байдлаар дахин шинэчлэн зохион байгуулах ажил хийгдэж байна. Ирэх 7 хоногоос Засгийн газрын тогтоолынх нь төсөлд санал авахаар Засгийн газар, бусад яамдууд руу гаргахаар ингээд төлөвлөөд ажиллаж байна.

Дээрээс нь орон нутгийн өмчийн цөм сүргүүд бас байдаг аа. Энэ орон нутгийн өмчийн цөм сүрэг дотор юу байдаг вэ гэхээр орон нутагт өсгөн үржүүлж...

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн нэмж тайлбарлая, хариулъя.

М.Ганхүлэг: Мандхай гишүүн чухал асуултуудыг асууж байна. Ерөнхий агуулгын хүрээнд тогтоолын төслийн агуулгууд дээр орсон байгаа. Ялангуяа энэ 3 жил тутам төлөв байдлын үнэлгээ хийхгүй байгаа учраас дараа дараагийн гарч байгаа энэ шийдвэр, үр дүнгүүд шинжлэх ухааны үндэслэлгүй байгаад байгаа юм. Тэр утгаараа бол одоо яг тодорхой хэд хэдэн удаа хийгээд хооронд нь харьцуулаад, тодорхой энэ 3 жилийн хугацаа давтамжийн үе үеүд дээр яаж өөрчлөгдөж байна, яаж ажиллах вэ гэдэг энэ бас гол үндэс суурь нь бэлэн болно оо. Энэ бол одоо ажлын хэсгийн хамгийн чухал асуудал байгаа юм. Тэрнээс биш зөвхөн хурдан морь байдаг юм уу, зөвхөн одоо бас хориглохтой холбогдолтой асуудал биш байгаад байгаа юмаа.

Тогтоолын төслийн гол агуулга дээр 2026 оны 4 дүгээр улирал гэхэд эхний үндсэндээ төлөв байдлын үнэлгээг гаргая гэдэг бүүр ийм хугацаатайгаар оруулж ирж байгаа. Тэгэхээр Засгийн газарт бол 2026 оны үндсэндээ улсын төсвийн асуудал яригдаж байгаа энэ цаг үед бол нэлээн бас одоо тодорхой заалт болж орно оо гэж бодож байна. 10 жилийн хугацаанд бол гурван ч удаа харьцуулах судалгаануудыг хийх бүрэн боломжтой.

Б.Бейсен: Гантулга гишүүн нэмээд хариулъя.

М.Ганхүлэг: Энэ хяналт шалгалтыг сайжруулах чиглэл дээр онцгой анхаарах шаардлагатай. Тэр чиглэлийн байгууллагуудад үндсэндээ чиглэл өгөх байдлаар бол дүгнэлтийг гаргаж байгаа. Гол нь бүртгэлжүүлж, цахимжуулж олон талын ийм бас хяналтуудыг бий болгох чиглэл дээр л ажиллах чиглэлээр ажлын хэсэг дээр яригдсан. Ялангуяа одоо үр хөврөлтэй холбогдолтой хүртэл асуудлыг хянаж шалгахад нэлээн хүндрэлтэй ийм асуудлууд тулгардаг. Иймэрхүү байдлууд дээр Гаалийн ерөнхий газар болон Засгийн газарт тодорхой чиглэлүүдийг өгөөд ажиллана. Яг байнгын одоо үндсэндээ ген фондыг хамгаалах чиглэлээр малын удмын сангийн үйл ажиллагаа түүнтэй холбогдолтой асуудлыг цаашдаа анхаарах ийм дүгнэлтүүд орж байгаа гэдгийг хэлье.

Б.Бейсен: Загджавын Мэндсайхан гишүүн асуулт асууя. .

З.Мэндсайхан: Малын генетик нөөцийг хамгаалах тухай тогтоолын төслийг манай зүүн бүсийн 5 гишүүн маань ингээд санаачлаад оруулаад ирж байгаа. Би энийг дэмжиж байгаа юмаа. Тэгэхээр мал бол одоо үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтад байна гэж үндсэн хуулийн заалт байдаг. Тэгээд энэ заалтыг бид нар агуулгыг нь нэг их тэгж тодруулдаггүй учраас нэг зуд турхны үед, мал малчдадаа туслах үед нь, төрийн хамгаалалтад хүнээсээ илүү мал нь төрийн хамгаалалтад байдаг ч гэдэг юм уу ийм яриа байдаг л даа. Тэгээд энэ тогтоол Үндсэн хуулийн тэр агуулгатай их нийцсэн ийм тогтоол орж ирж байгаа юм. Юу вэ гэхээр зэрэг ерөөсөө тэр үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтад байна гэдэг бол малынхаа таваарлаг байдлыг бий болгох, хамгаалах, тэр малчдынхаа өвөг дээдсийнхээ бий болгосон энэ малын удмын санг хамгаалах энэ асуудал төрийн бодлого байх ёстой.

Тэгэхээр энэ үндсэн хуулийн энэ заалтад их дөхөж очсон ийм тогтоол орж ирж байна гэж би бодож байгаа юм. Тийм учраас би дэмжиж байна аа. Ер нь зүгээр одоо энэ цаашдаа бид нар үржлийн адууг хилээр импортлохыг 10 жилээр хориглоё гэсэн энэ тогтоолын төсөл дээр байна. Миний хувьд бас уяачид гайхах л байх. Би одоо өөрөө энэ чиглэлийн хүн л дээ. Энэ өв соёлоо дээдэлж, энэ Монгол адууны хурдлах талд нь, үржүүлэг өөрийн гэсэн үржил селекцийн ажлыг зохион байгуулаад явдаг. Гэхдээ цаана нь юу харагдаад байна вэ гэхээр өнөөдөр монголчуудын маань хамгийн том цаашдаа таваарлаг байдлыг бий болгох, мал махны экспортод түлхэц үзүүлэх салбар чинь өөрөө энэ адуу байхгүй юу. Маш бага халдварт өвчинд өртдөг тиймээ, экспортын маш том орон зайтай. Энэ импортын асуудлаас болоод бид нар энэ таваарлаг байдлаа орхиод энэ хурдны чиглэл рүү нь яваад байгаа юм. Энийг чинь дагаад дотоодын манай малчдын маань дотооддоо бий болж байгаа хүндрэл юу вэ гэхээр зэрэг энийг дагаад л малчдын маань мал махны үнэ унадаг тэр асуудал чинь яг ялгаатай энэнтэй ялгаагүй байхгүй юу.

Одоо энэ тоон дээр 5 мянга гаруй үржлийн мал орж ирсэн байна. Тэрийг дагаад хэчнээн мал эрлийзчихэв тиймээ. Энэ бол одоо хуучин бол энэ зүүн талдаа түрүүн Батжаргал гишүүн хэлж байна лээ. Байгалийнхаа газар зүйн заалттай холбоотойгоор малын маань ясны бүтэц, тэр хурдлах чадвар нь өөр байдаг. Баруун бүс рүүгээ энэ төвийн бүс рүүгээ таваарлаг чанар нь илүү байдаг. Ялангуяа баруун бүс рүүгээ. Тэгээд энэ зохицоод ирсэн зүүлтүүд чинь өнөөдөр энэ үржлийн адуунаас болоод бас өөрчлөлт ороод явж байгаа. Энэ нь цаанаа бидний энэ өвөг дээдсийн бий болгоод ирсэн энэ мал сүргийн маань генетик нөөцөд нөлөөлнө өө гэж үзэж байгаа.

Тэгэхээр бид нар цаашдаа зүгээр энийг хориглоод өгснөөрөө тэр түрүүн ажлын хэсэг ярьж байна л даа. Генетик бид нар ийм ийм ажлууд хийнэ гээд. Тэр бол цаг хугацааны ажил аа. Гол том утгаараа бид нар эргээд малчид маань бид нартай бидэнгүй энэ үржил селекцийн ажлаа хийгээд, энэ байгаль цаг ууртад дассан хурдан болон таваарлаг адуугаа бий болгоод явчих тэр боломж нь энэ тогтоолын хүрээнд үүснэ гэж харж байгаа. Би нэг минутаа нэмчихье.

Б.Бейсен: Нэмээд нэг минут олгоё.

3.Мэндсайхан: Миний асуух гээд байгаа юм ажлын хэсгээс. Стандарт тогтоолоо гээд яриад байгаа юм аа. Би тэгээд энэнтэй би бол ерөөсөө санал нийлдэггүй юмаа. Одоо та бид хэд чинь бүгдээрээ монгол хүн тиймээ. Тэгээд бид нарын ер нь стандарт юу юм бэ. Тэгээд амьд амьтанд стандарт тогтоогоод тэрүүгээрээ ингээд л нэг тийм хэрүүлийн бай л болоод яваад байгаа юм л даа. Одоо тэгээд нөгөө нэг бас тэрнээс өөрөөр шийдэх аргагүй болчихоод л нэг хэмждэг барьдаг ийм стандарт тогтоогоод.

Тэгээд наад стандарт дотор чинь би нэг ганцхан юмыг асууя. Соёолон адуу 5 настай адуу 140 см тиймээ. Азарга болоод хойтон жил нь 6 настай болох юм бол 140 болно. Их морь болох юм хөнгөлчих юм бол 141 болчихно. Тэгээд энэ дээр та нар яг ямар шинжлэх ухааныг бариад азарга болохоороо өсдөггүй, морь болохоороо 1 см өсөөд гаргаж ирдэг ийм будилаан тариад хаячхав аа. Энэ стандарт тогтоогоод байгаа юмандаа та хэд маань яг юу баримтлаад ийм юм гаргаад ирсэн юм. Наадах чинь дахиад хэрүүл. Тэгээд энэ дээрээ та нар нэг шинжлэх ухаанч хариулт өгөөч ээ.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 5 номер.

Ц.Мөнхнасан: Мэндсайхан гишүүний асуултад хариулъя аа. Ахиад нөгөө бид нар зөвхөн гадаад шинж тэмдгээр нь стандартыг тогтоож байгаа гэдгийг дахин хэлье. Стандартыг тогтоохдоо монгол үүлдрийн адууны тодорхойлолт, үүлдрийн тодорхойлолт, Тэс үүлдрийн адууны үүлдрийн тодорхойлолт дахиад дээрээс нь гал шар үүлдрийн адууны үүлдрийн тодорхойлолт үлдсэн 3 омгийн адууны үүлдрийн тодорхойлолт дээр суурилж байгаа. Эдгээр үүлдрийн тодорхойлолтуудыг 1990 оноос эхлээд Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэн, ХААИС-ийн эрдэмтэд тодорхой давтамжтай судалгааны үр дүнд саяын бид нарын хэлсэн биеийн 5 үндсэн хэмжээсийг тогтоож өгсөн байдаг аа. Эдгээр шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанууд дээр суурилж стандартыг боловсруулж байгаа. Яагаад шинжлэх ухааны үндэслэлтэй гэж хэлж байна вэ гэхээр эдгээр судалгааны ажлуудын арга зүйг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр оруулж батлуулсан байдаг юмаа.

Батлагдсан арга зүйн дагуу хийгдсэн судалгааны үр дүн дээр ахиад эрдмийн зөвлөлийн хурлаар оруулаад эрдмийн зөвлөлийн хурлын санал, дүгнэлтийн дагуу санал дүгнэлттэйгээр эрх батлах эрх бүхий байгууллагуудад нь хүргүүлсэн байдаг аа. Эдгээр судалгааны материалуудыг үндэслэсэн. Дээр нь 1900 оноос эхлээд монгол адууны чиглэлээр судалгаа хийсэн. Гадаад, дотоодын эрдэмтдийн судалгааны өгүүлэл нэг сэдэвт бүтээлүүдээс бас эшлэл авч ингэж боловсруулсан байгаа.

Б.Бейсен: Мэндсайхан гишүүн тодруулъя.

3.Мэндсайхан: Харин тийм. Тэгэхээр би юу хэлэх гээд байгаа гэхээр зэрэг та нар үүлдэрлэг байдлаар нь тодорхойлоод явна гэдэг ерөөсөө та нар энэ 10 жилдээ чадахгүй юм байхгүй юу яг үнэхээр. Яагаад гэхээр чиний түрүүний дурдаад байгаа үүлдэр омгууд чинь бүгд газар зүйн заалтаараа өөр өөр. Зүүн бүс далайн түвшнээс доор учраас тэнд тэр тал нутаг учраас тэнд төрж байгаа малын яс хөнгөн, арьс нимгэн байгаад байна аа. Уулархгаа дагаад энэ малын чинь газарзүйн заалтаа дагаад малын чинь бүтэц өөрчлөгдөөд байгаа байхгүй юу. Энийг та нар үүлдэрлэг байдлаар нь тогтоогоод, ингээд маргааныг хагалаад явна гэх юм та нар бүр энэ нөгөө нэг хэмжиж бариад ингээд нэг учраа олж байсан юмыг бүүр будилааныг нь бүр буцаагаад үүсгэнэ шүү. Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр тэр стандарт гэдэг юмаа нэг эргээд хараарай. Энд цаашид авах арга хэмжээнийхээ талаар та нар харин тогтоолдоо хугацаагаа жоохон бодитой оруулах хэрэгтэй.

Энэ хөрөнгө мөнгөний асуудлаас болоод явдаггүй шүү дээ. Та нар адууны гений дараалал тогтооно гэдэг ямар мөнгө, цаг хугацаа зарцуулах ажил гэдгийг өөрсдөө мэдэж байгаа. Тэгээд...

Б.Бейсен: Мэндсайхан гишүүн гүйцээе.

3.Мэндсайхан: Тийм учраас та нар тогтоол дээрээ өөрсдөө яг тэр дотоод нөөц бололцоондоо тулгуурласан хугацаагаа тавьж орж ирээч ээ. Тэгэхгүй бол энэ чинь Их Хурал дээр очоод яг энүүгээрээ унана шүү. Хоёрдугаарт юу вэ гэхээр зэрэг жил бүрийн 4 дүгээр улиралд багтаагаад ингээд бид нар хэрэгжээгүй учраас хойшлуулъя гэдэг нэг ийм тогтоолтой болж хувирна шүү. Хэзээ ч хэрэгждэггүй. Тэгэхээр яг бодитой оруулж ирээрэй. Би одоо энийг харин Их Хурал дээр орж ирэхэд нь тэрийг нь сайн харна шүү. Бусдаар бол дэмжиж байна. Баярлалаа.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж дуусаж байна. Би нэг Малын генетикийн нөөцийн тухай хууль болон монгол үүлдрийн омгийн адууны удмын санг хамгаалах асуудлыг нь дэмжиж байгаа юмаа. Тэгээд нэг юм асууя. Одоо 25-тай, 50-тай, 75-тай цустай адуу гээд тэгж байна. Энэ дээр стандарт тогтоочихсон юм уу? Ер нь Монгол орны эрс тэс хүйтэн уур амьсгалтай юунд сүрэг адуунд явахгүй, өвөлдөө нэг бас дулаан газар хашаандаа тэжээдэг асуудал байж байна. Тэгэхээр чинь энэ малчид маань сая Батжаргал гишүүний ярьдгаар үржлээ хийгээд л хөдөө явж л байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг яг стандарт тогтоочихсон юм уу, энийг ямар утгаараа ингэж ярьж байдаг юм тэр талаар асууя. 5 номер хариулъя.

Ц.Мөнхнасан: Бейсен гишүүний асуултад хариулъя. Энэхүү стандарт гээд яриад байгаа зүйл маань сая хэлдэг монгол 3 үүлдрийн омгийн адуу, 3 үүлдрийн адуу тус бүрдээ биеийн хэмжээс нь өөр өөр байгаад байгаа юм. Тэгэхээр зөвхөн Монгол орны газар нутаг дээр бий болсон ардын селекцийн аргаар бүрэлдэн тогтсон энэ өвөрмөц шинж тэмдэг бүхий адуунууд дээр стандарт тогтоож байгаа. Бусад одоо гадаадын үүлдрүүдтэй цус холилдсон адуунууд дээр стандартыг бид нар тогтоогоогүй байгаа гэдгийг хариулъя аа.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж дууслаа. Санал, дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу нэрс өгнө үү? Батжаргал гишүүнээр тасалъя. Батжаргал гишүүн үг хэлье.

Ж.Батжаргал: Үгүй ээ, бид хэд энэ тогтоолыг гаргахыг би бол дэмжиж байна. Зөв юм гэж. Гэхдээ энэ үүлдэр угсааг хамгаалах гэдэг юм уу, хөгжүүлэх гэдэг юм уу энэ юмнуудыг ярихаар хэрхэх вэ гэдэг л асуудал яригддаг. Яг өөрийг нь өөр дээр нь үүлдрийг үүлдэр дээр нь гэсэн үг шүү дээ. Хөгжүүлэлт хийж байгаа юмыг бид яагаад хаагаад байгаа юм. Монголтой нийлүүлж байгааг нь л хаагаад байгаа ухаантай юм байгаа биз дээ. Наад газар тариалангийн бүсэд чинь цэвэр жинхэнэ махны адууг оруулж ирээд өөр дээр нь хөгжүүлэлт хийгээд яваад байгаа улсууд байгаад байгаа байхгүй юу зайлуул. Тэгээд Япон руу тодорхой хэмжээний бүтээгдэхүүн энэ тэрийнхээ туршилтын байдлаар гаргах гээд энэ тэр яваад байгаа зүйл. Үгүй энүүнийг нь хэдүүлээ арваад жил хаачихаар зэрэг их л сонин л ойлголт болох гээд байна л даа. Тэгэхээр яаж энүүнийгээ зөв болгох уу л гэдэг асуудал. Би бол тэр монгол адууны яс чанарыг муутгах гэдэг юм уу, тэсвэрт чанарыг муутгах, барих тэр хооронд нь хольсон эрлийзжүүлэлт хийж байгаа юмыг хаахыг зөв өө ойлгож байна. Яг тэр өөрийнх нь үүлдрийг өөр дээр нь хөгжүүлэлтийг нь хийгээд, ашиг шимт чанарыг нь ашиглаад яваа энэ үйл явцыг бид хаагаад байгаа нь л эрсдэл дагуулах гээд байна л даа. Энүүнийгээ л бид нэлээн бодмоор юм байна.

Тэгээд одоо ямар ч үүлдрийн адуу авчирсан газар зүйн байршлаасаа хамаарч төллөлт явагдаад л ясны бүтцээсээ авхуулаад л саяын Мэндээгийн хэлдэг арьс, тэр бүх юмнууд нь тогтолтоороо тогтдог. Угаасаа байгалийн өөрийнх нь бүтээгдэхүүн учраас. Тийм учраас зүүн бүсийн монгол адуутай нь ч, эрлийз адуутай нь ч уралдах боломж хязгаарлагдмал. Угаасаа тэр газар зүй өөрийнх нь уг амьд амьтанд бий болгож байгаа давуу чанар байхгүй юу энэ чинь. Тэгэхээр энүүнийг л хэдүүлээ бодож нэг аятайхан зөв шийдлийг нь олоод л гаргачих юмсан л гэсэн санаа байна.

18.23 цаг

Б.Бейсен: Гишүүд үг хэлж дууслаа. Дараагийн асуудалд оръё.

Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Ажлын хэсэг хэвээрээ байгаа. Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Ганхүлэг гишүүн танилцуулна.

М.Ганхүлэг: Гишүүддээ баярлалаа. Малын генетик нөөцийг хамгаалах тухай талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төслийг та бүхэнд тараан өгсөн байгаа. Үндсэн 3 агуулгатай. Эхний агуулгын хүрээ буюу Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, монгол малын генетик нөөцийг хамгаалах, ашиглалтын тогтвортой байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авахыг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон байгаа. Хамгийн эхнийх нь саяын ярьсан төлөв байдлын үнэлгээг 2016 оны 4 дүгээр улиралд хийх, түүнтэй холбогдолтой төсөв, санхүү, зардлыг бас Засгийн газарт чиглэл болгож өгч байгаа.

Хоёр дахь нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд заасны дагуу бүс нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах, дэмжин хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар.

Гурав дахь нь үржлийн адуу, түүний үр хөврөлийг импортлох тоо хэмжээг 2026-аас 2036 он хүртэлх хугацаанд Засгийн газарт өгсөн эрхийн дагуу жил болгон

үндсэндээ тоо хэмжээг тогтоож оруулдаг. Энэхүү тоо хэмжээг бол 0 хувьтай байхаар гэдэг ийм агуулгаар оруулж ирж байгаа. Энэ нь бас худалдаа тарифын одоо хувьд хэлэлцээр гээд олон зүйлүүдийг зөрчилгүйгээр дундын ийм хувилбар байж болох юмаа гэдэг агуулгаар орж ирж байгаа юмаа. Үржлийн мал үржүүлгийн бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, ашиглах үйл ажиллагааны бүртгэл, хяналтыг сайжруулах, нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх гээд хяналт шалгалттай холбогдолтой агуулгыг оруулж ирсэн. Адуун сүргийн тархац, үүлдэрлэг байдлыг бүс нутгаар гаргах, үржлийн адуунд удам зүйн үнэлгээ хийх, бүртгэлжүүлэх, үндэсний хэмжээний мэдээллийн санг бүрдүүлэх, адуу судлал төрөлжилт, ашиглалтын нэгдсэн бодлогоор хөгжүүлэхэд зөвхөн төр биш хувийн хэвшил төрийн бус байгууллагуудын оролцоог бүрдүүлэх гэсэн ийм агуулгаар үндсэндээ тогтоолын төсөл гарч байгаа. Тэгээд дэмжиж өгөхийг хүсье гишүүдээсээ.

Б.Бейсен: Ажлын хэсгийн ахлагч Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүнд баярлалаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүн байхгүй байна. Үг хэлэх гишүүд байна уу нэрсээ өгнө үү? байхгүй байна.

Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлахыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт. Нэг санал хураалт байгаа хүлээж байгаарай.

Тогтоолын төсөл 81.3 хувиар батлагдлаа, дэмжигдлээ. Чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүнд чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулъя.

18.27 цаг

Дараагийн асуудалд оръё.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 79 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох.

Санал дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Уянгаа танилцуулна.

Б.Уянга: Гишүүддээ энэ оройн мэндийг хүргэе ээ. Их орой бүгдээрээ үргэлжлүүлэн хуралдаж байх шиг байна аа. Тэгээд ямартай ч ундны ус ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхтэй холбоотой. Үүний хэрэгжилттэй нь танилцаж, санал дүгнэлт гаргах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, энэ ажлын хэсгийн дүгнэлт саналыг танилцуулах хэрэгтэй. Тэгээд танилцуулгыг хийе ээ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 79 дүгээр захирамжаар ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн

Ж.Золжаргал, Э.Болормаа, М.Ганхүлэг, Л.Мөнхбаясгалан, П.Мөнхтулга, Д.Рэгдэл нар ажилласан.

Ундны ус ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдрөөс эхлэн 2025 оны 6 дугаар сарын 18-ны хугацаанд ажиллалаа.

Дээрх хугацаанд ажлын хэсгийн хуралдаануудаас гадна усны салбарын нээлттэй хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулсан. Мөн Усны компакт гэрээ буюу Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийг Мянганы солилтын корпорац Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлж буй ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах, хаягдал ус дахин боловсруулах төслүүд Улаанбаатар хотын төв цэнгэлдэх байгууламж болон ундны усны хангамжийн нөхцөл байдал зэрэгтэй газар дээр танилцаж ажилласан.

Ажлын хэсгийн хүрээнд Дундговь аймгийн Сайнцагаан, Говь-Угтаал, Гурвансайхан сумдад ажиллаж, ундны ус, ариун цэврийн байгууламжийн нөхцөл байдалтай танилцахын зэрэгцээ улсын хэмжээнд нийт сумдын ундны ус ариун цэврийн байгууламжийн судалгааг гаргаж ажиллалаа.

Мөн усны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгын хүрээнд Усны тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулиудын давхардал, зөрчил, хийдлийн судалгааг гүйцэтгэлээ.

Ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд ундны ус ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийн хэрэгжилт, эрх зүйн орчны талаар дараах дүгнэлтийг хийж байна аа.

Нэгдүгээрт Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт усны нөөц нь төрийн өмч бөгөөд усны хэрэглээ нөөцийг хамгаалах асуудлыг төр хариуцна. 16 дугаар зүйлийн 16.2-т Монгол Улсын иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй. Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.1-д ундны болон ахуйн ус нь эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангасан аюулгүй байна гэж тус тус хуульчилсан. Уг зохицуулалтаас үзэхэд ундны усны аюулгүй байдал ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийн талаар тусгайлан хуульчилж холбогдох ойлголтыг бүрэн хамруулаагүй байгаа нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд ойлгомжгүй хүндрэлтэй байдалтай байгааг харуулж байна аа. Өөрөөр хэлбэл ундны ус ариун цэврийн байгууламжаар хангагдах тухай хүний хууль ёсны эрх анхдагч хэрэгцээний талаар хууль эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байна гэж үзсэн.

Хоёрдугаарт Улсын Их Хурлын 2024 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний Монгол Улсын Их Хурал төвт хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн үзэл санааг төгөлдөржүүлнэ хэмээн тусгасан стратегийн нэгдэх зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд хүн амын ундны цэвэр ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдах суурь эрхийг хууль тогтоомжид цогцоор нь тусгаж, уг харилцааг зохицуулж буй байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгох, хууль тогтоомжийн давхардал, зөрчлийг арилгах шаардлагатай байна.

Гуравдугаарт, Монгол Улсын Засгийн газрын төлөвлөгөө батлах тухай 2021 оны 53 дугаар тогтоолоор Улаанбаатар хотод үйлдвэрлэл явуулж буй Ус суваг удирдах газартай гэрээт 284 ус бохирдуулагч аж ахуйн нэгжид бага оврын цэвэрлэх байгууламж барих үүрэг хүлээгдсэн. 2025 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн байдлаар арьс шир боловсруулах 12, ноос ноолуур боловсруулах 17, ундааны 1, мах боловсруулах 1, талх нарийн боовны нэг үйлдвэр нийт 32 аж ахуйн нэгж буюу 284 үйлдвэрээс 11 хувь нь хаягдал усаа цэвэрлэж байгууламж барьсан нь хангалтгүй үзүүлэлт буюу үйлдвэрүүд урьдчилан цэвэрлэх байгууламжгүй байгаагаас төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна аа. Монгол Улсын 330 сумын хүрээнд цэвэрлэх байгууламжтай 79 сум ундны усаа зөөвөрлөж хэрэглэдэг 33 сум байгаа нь нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хангалтгүй хэмжээний үзүүлэлттэй байх тул уг асуудалд бид нар анхаарах хэрэгтэй байгаа.

5 дугаарт улсын хэмжээнд 2019-2022 оны хооронд ШУА-ийн Газар зүй гео экологийн хүрээлэн болон Хими химийн технологийн хүрээлэнгийн судлаачид НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран 21 аймаг, 330 сум, Улаанбаатар хотын 9 дүүргийн гүний худаг болон төвлөрсөн шугам сүлжээний 3582 ус цэгээс дээж авч, дэлгэрэнгүй шинжилгээ хийжээ. Хөрсний бохирдол ихтэй, цэвэр усны шугамын ган хоолой зэвдэнд идэгддэг тул усны чанарын судалгааг шинэчлэн гүйцэтгэх, түүнчлэн зэвтэй ган хоолойг зэвэрдэггүй материалтай хоолойгоор солих шаардлагатай байна аа.

Ажлын хэсгийн нэгдсэн санал, дүгнэлт, зөвлөмжийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хүргүүлж, асуудлыг шийдвэрлэх боломж нөхцөлийг судлуулах, хамтран ажиллах замаар үүсээд буй хүндрэлтэй нөхцөл байдал тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа.

Ингээд ажлын хэсгийн санал зөвлөмжийг танилцуулъя аа. Ундны ус ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийн хэрэгжилттэй танилцаж, санал дүгнэлт гаргах эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны үр дүнд үндэслэн дараах санал зөвлөмжийг ажлын хэсгийн гишүүд гаргасан байгаа. Тэгэхээр 3 хэсгээс 4 хэсгээс бүрдэж байгаа. Институцийн зохион байгуулалтыг сайжруулах, төсөл хөтөлбөрүүдийн үр дүнг сайжруулах, улсын хэмжээнд усны эрүүл ахуй, судалгаа шинжилгээний ажилд анхаарах хэрэгтэй байгаа. Мөн хуулийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлын хүрээнд их олон асуудлыг хийх шаардлагатай байна аа.

Тэгээд энэ ажлын хэсгийн санал зөвлөмж бол гишүүдэд тараагдсан байгаа учраас яг энэ ажлын хэсэгтэй холбоотой хэрвээ асуудал санал байвал тэмдэглэж авъя. Тэгээд энэ 4 дэх байна уу, 5 дахь өдөр Улсын Их Хурлын даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг учраас Их Хурлын даргад ажлын хэсгийн гишүүд орж танилцуулж байгаа. Тэгээд үүнээс дараа нь Улсын Их Хурал руу орж бүх гишүүдэд танилцуулах шаардлагатай тохиолдолд танилцуулаад, үгүй тохиолдолд Байнгын хорооны тогтоол байдлаар холбогдох яамд бас агуулгыг хүргүүлэх шаардлагатай байгаа. Тэгэхээр ямартай ч ажлын хэсэг 2024 оны 9 сараас хойш ажиллалаа. Нэгдсэн тайлан бол боогдож дууссан байна. Тэгээд ер нь бол устай холбоотой аливаа өнөөдрийг хүртэл хийгдсэн төрийн байгууллага болон холбогдох төрийн бус байгууллагууд бусад байгууллагуудын асуудлуудыг нэгтгэсэн тайлан гарсан учраас энэ ажлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүд бас сонирхсон тохиолдолд өгөхөд бэлэн байгаа гэдгээ илэрхийлье ээ. Баярлалаа.

Б.Бейсен: Ажлын хэсгийн ахлагч Болдын Уянга гишүүнд баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу гишүүд байна уу? Нэрсээ өгөөрэй. Сэддорж гишүүнээр тасалъя. Жигжидийн Батжаргал гишүүний асуусан. Ирцээр нь яачихсан юм байна. Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Тийм нэлээн чухал ажлын хэсэг байна аа. Тэгээд ундны усны стандартад нийцэж байгаа эсэх хяналт шалгалтыг хийж үзэхэд Монгол Улсын суурин төвлөрсөн газрын 51 хувь нь ундны усны стандарт шаардлагыг хангахгүй гэсэн ийм дүгнэлт гарсан байдаг. Нөгөө талдаа бид нар байгаль орчны чиглэл дээр төсөв мөнгийг маш бага харамласан байдлаар тавьдаг. Үүнээс улбаатай өнөөдөр усны хайгуул ялангуяа ундны усны хайгуултай холбоотой асуудал бол бараг хийгдэхгүй байгаа гэж хэлэхэд болно. Бид нар цаашдаа хэд хэдэн асуудлыг анхаармаар байгаа юм.

Нэгдүгээрт энэ ундны усны хайгуултай холбоотой асуудлуудыг нэг мөр шийдвэрлэхгүй бол цаашдаа үүнээс улбаатай усны хомсдол үүсэх эрсдэлт нөхцөл байдал нэгдүгээрт үүсэж байгаа юм.

Хоёрдугаарт ундны усны нөөцийн газрыг тухайн аймаг орон нутаг хамгаалалтад авсан байдаг. Гэтэл тэнд нь сүүлийн үед барилга байшин барих, хөндөх ийм асуудлууд хөндөгдчихөж байгаа юм.

Гуравдугаарт цэвдгийн бүсийг бид нар хайрлаж хамгаалахгүй бол 1976 оны үед Монгол Улсын нийт газар нутгийн 63 орчим хувь нь цэвдэгтэй байсан. 2015 онд 29 хувь болж буурсан. Өөрөөр хэлбэл бид нар 34 хувиа дөчхөн жилийн дотор бараг алдчихсан гэсэн үг. Одоогийн байгаа тооцоогоор хэрвээ энэ янзаараа явах юм 2050 он гэхэд Монгол Улсын цэвдгийн хэмжээ 16 хувьд очно. Дахиад бид нар 13 хувиа алдаж байгаа гэсэн үг. Энэ бол уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай. Би яагаад цэвдгийн асуудлыг хөндөж байгаа вэ гэхээр энэ хүссэн ч, эс хүссэн ч устай холбогдож байгаа хэсэг, хөрстэй холбогдож байгаа хэсэг. Тэгээд бид нар энэ усан дээр ерөөсөө анхаарахгүй яваад байгаа учраас энэ дээр бол хэд хэдэн ийм бодлогын хүрээний асуудлуудыг их зөв гаргаж тавиач ээ гэж хүсэж байгаа юм.

Манай усны агентлаг байгаа. Усны агентлаг бол би Авлигатай тэмцэх газарт хүртэл тодорхой материалуудыг гаргаж өгч байсан. Усны агентлаг нь өөрөө усныхаа эсрэг бараг шахуу болчихсон байсан ний нуугүй хэлэхэд. Бид нар энэ усны агентлагийн яг мэргэжлийнх нь дагуу зөв ажил олж, зөв зохион байгуулалттай хийхгүй бол болохгүй байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам 330 сум 333 хөв цөөрөм ч билүү нэг үйл ажиллагаа хийгээд явж байгаа. Бид нар сум болгонд нэг хувь цөөрөм байх ёстой гэж харж байгаа. Энэ ажил бол зөв ажил. Энэ ажлыг бид нар хөрөнгө санхүү төсвөөр дэмжих ёстой. Дээрээс нь бол зөв эрх зүйн орчных нь зохицуулалтыг хийж өгөхгүй бол байгаль орчны 33 багц хууль дээр багц хуулиуд дээр нэг минут нэмээд авчих уу.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүнд нэг минут. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүнд нэг минут.

Б.Бат-Эрдэнэ: Байгаль орчны багц хууль буюу 33 хуульд дүн шинжилгээ хийгээд үзэхэд 335 орчим хийдэл, зөрчил, давхардал илэрсэн. Бид нар энэнтэй холбоотой асуудлаа нэг мөр шийдвэрлэхгүй бол ундны устай холбоотой асуудал

дээр асуудал үүснэ ээ. Энэ бол нэг мөр шийдвэрлэгдэж явж чадахгүй байгаа гэдгийг би хэлье. Тэгээд энэ ундны устай холбоотой асуудал дээр бид нар онцгойлон анхаарч, 2026 оны улсын төсвөөс авхуулаад одоогоос бид нар анхаарахгүй бол үе үеийн сайд нартай холбоотой тэгээд дээрээс нь тухайн бүтэц бүрэлдэхүүнтэй холбоотой, устай холбоотой ийм асуудлууд бол хөндөгддөг юмаа. Тэгээд энэ дээр бол бас яг энэ ундны ус ариун цэврийн байгууламжаар хангагдах эрх эрхийн хэрэгжилттэй танилцаад, ажил, санал дүгнэлт гаргаад эрх зүйн орчныг боловсронгуй болгох, боловсруулах, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг явж байгаа учраас албан ёсоор энэ дээр хэлж үлдээж байгаа юмаа. Асуулт алга аа, дэмжиж байна. Баярлалаа.

Б.Бейсен: Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Хэдхэн зүйл байна. Нэгдүгээрт энэ усны хайгуул судалгааны ажилд гаргах мөнгийг нэмэгдүүлмээр байгаа юм нэгд, хоёр дахь зүйл бид юмыг цогцоор нь хармаар байна л даа. Сургууль, дотуур байрыг ариун цэврийн байгууламжтай болгоно гээд бодлогын нэгдмэл байдлыг алдагдуулсан мөнгө үрчхэж байгаа байхгүй юу. Хүн амьдарч байгаа суурин газар л юм бол тэнд өөрөө угаасаа энэ цэвэрлэх байгууламж, ариутгал татуургын чинь асуудал шийдэгдэх ёстой шүү дээ. Тэгэхээр нэгдсэн нэг юман дээр бусад бүрдүүлж байгаа салбарууд нь хамтарч ажилладаг хэлбэрээрээ хийгдэх ёстой байхгүй юу. Сумын хэмжээний ариун цэврийн байгууламж гэж. Дараа нь хэдүүлээ саарал ус ашиглах тухай юм ярьдаг юм. Тэгвэл одоо энэ шинэ хорооллууд гэдэг юм уу, шинэ орон сууцууд гэдэг юм уу дам дамаан тэр цэвэрлэх байгууламжтай газрууд дээр, тэр ариутгал юу цэвэрлэх байгууламжаас гарч байгаа саарал усыг ашигладаг технологийг нь, шугам сүлжээг нь хийж өгөхгүйгээр бид хуучин барилга байгууламж эд нар явах ямар ч боломж байхгүй шүү дээ. Тэгэхээр стандартаа шинэчлэх тухай асуудал байгаад байгаа юм. Нэг бол одоо энэ ариун цэврийн байгууламж ариутгал татуургуудыг түшиглэж, цэвэрлэх байгууламжуудыг түшиглэж түүгээр гарч ирж байгаа усыг ашиглаж болдог тэр зүйлсийг нь бий болгож өгөх ёстой. Тэр модоо тарьдаг юм уу, юугаа яадаг юм. Тэр усалгааны системээр нь.

Тэгэхгүй тэгээд нэг хэсэг цэвэр гэдэг юм уу, ундны усны нөөцөөрөө өөр ажлууд хийгээд, ариутгал татуургынх нь саарал ус тэр чигтээ зайлаад байгаа ийм л үйл явц яваад байгаа байхгүй юу. Энийгээ нэг бодмоор санагдаад болж өгөхгүй байгаа миний бодлоор бол. Дараагийн нэг хэлмээр байгаа зүйл тэр сум суурин газруудын 50-иад төв гэдэг үнэн байх. Бат-Эрдэнийг би тийм тоо сайд байхдаа бодоход мэдээж нэлээн анхаарал хандуулж ажиллаж байсан байлгүй гэж бодож байна. Тэр нэг 30 хэдэн сумын төв гэж байна. Тэр чинь шинжилгээгээр ерөөсөө ундны усны хэрэглээнд таардаггүй уснууд байгаад байдаг. Тийм учраас алсаас зөөвөрлөлт хийдэг. Уг сумын төв өөрөө байршсан тэр нөхцөл нь ундны усныхаа стандартыг огт хангадаггүй. Одоо жишээ нь манай Мөнгөн морьтоос авхуулаад байж байгаа байхгүй юу. Тэр 30 хэдэн юу сумдын 50 хэдэн хувь гэдэг чинь орчны бохирдлоос хамааралтай, эсвэл хүнд элементүүдийн тодорхой нэг элемент нь өндөр ч гэдэг юм уу ийм байдлаас хамаараад ундны усны асуудал дээр асуудал үүсгээд байдаг. Бид хэд нэг баахан цэвэрлэх ус цэвэршүүлэгч гэдэг юмыг ундны усны эх үүсвэр дээр тавьсан. Үнэндээ ашиглалтын технологи нь хангагддаггүй байхгүй юу. Тэгэхээр энүүнийг ер нь яаж зөв болгож энэ иргэдийг баталгаат ундны усаар хангах тухай асуудлыг шийдэх юм бэ гэж...

Б.Бейсен: Батжаргал гишүүн гүйцээж асууя.

Ж.Батжаргал: Энэ асуудлуудыг дүгнэлтдээ нэлээн тодорхой оруулаад, Их Хурлын даргад танилцуулаад Их Хурлын дарга юу гэж чиглэдэг юм. Байнгын хорооноосоо тогтоол тогтоолын хавсралттайгаар холбогдох газар нь хүргүүлж байж саяын энэ ажлын хэсэг ажилласны үр дүн төрийн бодлогод шийдлээ олж тусах болов уу гэж би ингэж бодоод байгаа. Энэ нэг гадагшаа урсгалтай гадаргын усныхаа ашиглалтыг яах юм бэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Том юм хийе гэхээр зэрэг хаяа залган амьдарч байгаа улс орнууд чагт тавьчихаад болж өгөхгүй юм. Жижиг юмнууд яагаад хийж болохгүй байна аа. Бид хэд хүний анхаарал татахааргүй жижиг юмнууд хажууд нь яагаад байгуулаад байж болохгүй байна.

Тэгэхээр энэ гадагшаа гэдэг юм уу хүний рүү чиглэсэн урсгалтай гадаргын усыг бид байж болох хэмжээнд нь бүрэн ашиглах ёстой юмаа. Худлаа үнэн жигтэйхэн олон улсын хууль дүрэм ярьцгаагаад байцгаагаад байгаа улс байхгүй юу бид. Энэнээс л нэг зайлсхиймээр санагдаад байгаа юм би бол.

Б.Бейсен: Уянга гишүүн хариулъя.

Б.Уянга: Батжаргал гишүүнд маш их баярлалаа. Таны хэлсэн саналуудтай бүрэн дүүрэн санал нэгдэж байгаа. Тэгээд өнөөдөр яг Байнгын хороонд танилцуулсан хэсэг бол ажлын хэсгийн нэгтгэсэн дүгнэлт байлаа. Яг миний яг нэг нэгэнгүй уншсан нь. Тэгээд санал зөвлөмж бол яах вэ бас тодорхой багцалсан байдлаар байгаа. Тэгээд энэ ажлын хэсэг ажиллах хүрээнд бол холбогдох байгууллагуудтай уулзаад, дэлгэрэнгүй асуудлуудыг нь бичсэн эсэх нь энэ нэгтгэсэн байгаа тайлан маань юм байгаа юм. Тэгээд Байнгын хорооноосоо холбогдох яамдууд руу нь яг таслаад, Барилга хот, байгуулалт, орон сууцжуулалтын яам руу аль нь явах юм. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам руу, Хэрэг эрхлэх рүү аль нь явах юм гэдгээр нь хуваагаад тогтоолууд оруулах нь зөв гэдэгтэй санал нэгдэж байгаа.

Тэгээд Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг учраас ажлын Их Хурлын даргад гишүүдийнхээ хамтаар орж тайлагнахаасаа өмнө Байнгын хороондоо танилцуулъя гэдэг үүднээс өнөөдөр орж ирсэн юм байгаа юмаа. Тэгээд хайгуул газрын доорх усны хайгуул судалгааны ажлыг сайжруулах хүрээнд төсөв бол хаанаа ч хүрдэггүй юм байна. Тэгээд Усны газрын дарга Батбаяр даргатай сүүлд уулзахад бол тооцооллоо хийсэн, 5 жил дараалаад нэг жил жил болгон 10 тэрбум төгрөг манай төсөв дээр тавиад өгчихвөл газрын доорх усны судалгааг нэлээн сайн хийх боломжтой байна гэсэн тооцоолол танилцуулсан. Тэгээд тэр нь мэдээж нарийвчлагдаж байгаа байх аа. Тэгээд Байнгын хороо Байгаль орчны байнгын хороо бол яг энэ устай холбоотой хамгийн гол бодлогын асуудлыг базах Байнгын хороо учраас дараа дараагийн нарийвчилсан тогтоолуудыг оруулж ирэх ийм бол бодолтой байна. Тэгээд Их Хурлын даргатай ажлын хэсгийн гишүүд нийлж сууж яриад тэгээд холбогдох тогтоолын төслүүдийг бэлдээд оруулж ирье. Тэгээд Батжаргал гишүүнд мөн Бат-Эрдэнэ гишүүнд энэ ажлын хэсгийн нэгдсэн ийм задгай тайланг өгөх хэрэгтэй байх. Тэгээд сум сумдаар нь гарсан мэдээллийг бас харах боломжтой.

Б.Бейсен: Сэддорж гишүүн байхгүй юм байна. Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Отгонбаяр гишүүн үг хэлье. Отгонбаяр гишүүний микрофон.

У.Отгонбаяр: Уянгаа гишүүндээ баярласан талархсанаа илэрхийлье ээ. Энэ ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийн хэрэгжилттэй танилцах ажлын хэсгийн үндсэндээ урьдчилсан байдлаар би дүгнэлт гарсан байна гэж ойлгож байна. Тэгээд энэ дээр зүгээр та бүгд маань ажлын хэсэг дээрээ еще дахиад яригдах байх. Ус хангамж ариутгах татуургыг татуургын ашиглалт өгч үйлчилгээг зохицуулах зөвлөл гэж байгаа. Барилга, хот байгуулалтын сайдын харьяанд байгаа. Энэ зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг та бас нэг, болдог бол бас нэг танилцаарай. Тэднийх үндсэндээ энэ СӨХ-үүдийн зөвшөөрөл өгөөд, тэрэн дээр нь хяналт тавьсан маягтай нэг иймэрхүү үйл ажиллагаа явуулдаг. Миний бодлоор энэ ундны ус, энэ ариун цэврийн байгууламжтай бол бас салшгүй холбоотой ийм зохицуулах зөвлөл байгаа юм. Тэгээд зохицуулах зөвлөлийн дарга нь нэг 6 жилээр билүү томилогддог Засгийн газраас. Тэгээд нэг 20, 30 хүнтэй ний нуугүй хэлэхэд бас бодлого, үйл ажиллагааг нь еще сайжруулах, арай нэг ахисан түвшинд гаргах зайлшгүй шаардлага байдаг юм болов уу гэж би зүгээр хөндлөнгөөс бас хардаг юм. Тэр яаманд ажиллаж байсан хүний хувьд. Энэнтэй бол одоо бас салшгүй нэг хэсэг. Нөгөө зоосны 2 тал шиг л гэж хэлж болохоор ийм зүйл байгаа гэдгийг бас хэлье.

Тэгээд ариутгах биш ээ, ус хангамж ариутгах татуургын тухай хууль байгаа. Энэ хуультай энэ ажлын хэсгийн дүгнэлт нэлээн уялдах болов уу гэж би хувьдаа ойлгож байгаа. Тэгээд энэ 2 саналыг л ажлын хэсгийнх нь дүгнэлттэй холбогдуулж хэлье. Баярлалаа. Амжилт хүсье.

Б.Бейсен: Гишүүд үг хэлж дууслаа. Энэ яах аргагүй чухал асуудал. Энэ Их Хурлын даргын захирамжаар энэ 79 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг байгаа. Ундны усны асуудал нөгөө талаар үндэсний аюулгүй байдалтай бас холбоотой асуудал. Жишээлбэл манайх чинь одоо нүүдлийн мал аж ахуйтай, сум, багийн түвшинд айлуудаас нүүдэг энэ ийм байдалтай. Гэтэл одоо хавар, өвлийн цагт гэдэсний халдвар бас гардаг. Энэ ундны устай холбоотой. Нөгөө талаараа говийн усыг ярьж байна. Одоо гүний усны асуудал. Батжаргал гишүүн сая ярьсан. Голоосоо гадагшаа урсаж гарч байгаа, голоосоо хоолой татаж ер нь яахад буруудах юм байхгүй байх. Одоо Энэтхэг, Пакистанд ус өгөхгүй гэдэг асуудал тавьж байна шүү дээ. Заавал тэд нараас хуулиа баримтлаад олон улсын юм гээд айгаад байх юм байхгүй. Энэ хулгайн аргаар ч гэсэн говийн аймгуудад ус татмаар санагдаад байгаа юм ерөөсөө. Энэ том том голуудаас.

Тэгэхээр энэ үнэхээр одоо говийн тэр урантай холбоотой тэр гүний усны найрлага нь ямар байдаг юм тэр талын асуудлыг бас судалгаа хийх шаардлагатай нэгдүгээрт. Хоёрдугаарт зарим уурхайтай газруудын усыг ашиглаж байна ард иргэд. Энэнтэй холбоотой бас өвчин гарч байгаа. Жишээлбэл хотгорын уурхай бас ус ашиглаж байсан. Бид нар сая нэг цистерн авч өгсөн усны цистерн. Тэрүүгээр тэгээд л усыг нь зөөж байгаа гэх мэт. Зарим аймаг, сумын түвшинд усны машинаар ус зөөж байгаа асуудлууд байгаа. Усны найрлагыг нь төгс судлах шаардлагатай байгаа. Энэ усны талын гүйцэд судалгаа шинжилгээ нь Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнд байдаг. Хуучин Эрүүл ахуйн халдвар судлалын институт гээд байхад энийг одоо судалгаа шинжилгээг нь сайн хийдэг байсан. Газрыг нь авахын тулд энэ Эрүүл ахуйн халдвар судлалын институтийг тараагаад, мэргэжлийн хяналт албад хагасыг нь явуулаад, хагасыг нь Нийгмийн эрүүл мэндийн яаманд хүргээд тэр одоо нөгөө зүүн 4 зам тэнд газрыг нь булаагаад авсан шүү дээ. Тэгээд энэ том байгууллагыг тараагаад дууссан. Тухайн үеийн удирдлагуудын бас алдаатай бодлого л доо.

Тийм учраас Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн дээр нь ундны усаа хориулсан мэргэжилтэн байгаа бүр, судлаачид байгаа. Эд нартай холбогдоод энэ нарийн судалгааг нь аваад тэгээд Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан учраас ажлын хэсгийнхэнтэй хамтраад Их Хурлын даргад танилцуул. Тэгээд манай Байнгын хорооны зүгээс энийг дэмжиж ажиллана. Тогтоол гаргавал тогтоол гаргахад бид бэлэн байгаа. Үнэхээр чухал асуудал. Одоо энэ ундны ус гэхээр чинь усны үйлдвэрүүд байдаг юм. Гаднаас бас ус орж ирж байгаа шүү дээ манайд. Өөрсдөө устай мөртөө.

Тэгэхээр энэ асуудлыг бас үнэхээр Их Хурлын хэмжээнд ярих нь зөв байх гэж бодож байна. Танилцуулсан Уянгаа гишүүндээ дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн Уянгаа гишүүнд бас баярлалаа. Ецэ энийг бас нарийн энэ юундаа тусгаад Их Хурлын даргадаа танилцуулна гэж бодож байна. Сая нөгөө нийгмийн эрүүл мэнд, Эрүүл мэндийн яам энэ тэрээс бас судалгааг нь авах хэрэгтэй байна. Байгаль орчны яаманд бас энэ усны асуудал хариуцсан улсууд байгаа. Тэд нараас хамгийн сайн мэдээллийг нь Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн ундны ус хариуцсан мэргэжилтэн Эрүүл мэндийн яамны ийм хариуцсан орчны юу хариуцсан улсууд байгаа. Тэд нараас бас авсан нь зөв байх гэж бодож байна.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаан дууссаныг мэдэгдье ээ. Ажлын хэсэгт баярлалаа.

18.52 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА